

**ТӨСВИЙН БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООДЫН
ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2026 оны 5 дугаар сарын 26-ны өдөр, Мягмар гараг**

| | |
|--|------|
| Хуралдааны тэмдэглэлийн агуулга | 1 |
| Хуралдааны товч тэмдэглэл: | 2-4 |
| Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: | 5-36 |

- 1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/** 5-11
 - 2. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/** 11-17
 - 3. Нэмэгдсэн ертгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Монгол Улсын нэгдсэн төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/** 17-36
-

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын
5 дугаар сарын 26-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хамтарсан хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Н.Наранбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 56 гишүүнээс 29 гишүүн хүрэлцэн ирж, 51.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 54 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Аубакир, Ж.Батсуурь, Ч.Лодойсамбуу, Р.Сэддорж, А.Ундраа;

Чөлөөтэй: Д.Батбаяр, Ж.Баясгалан, П.Мөнхтулга, Ж.Золжаргал, Б.Уянга;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Баатархүү, Э.Одбаяр, Б.Чойжилсүрэн;

Тасалсан: Ч.Анар, Б.Жавхлан, Г.Очирбат, О.Цогтгэрэл.

Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Даваасүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга Б.Төгөлдөр, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан, мөн зөвлөлийн гишүүн Л.Отгонтуяа, Н.Ууганбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа, С.Тэгшжаргал, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал, С.Эрдэнэбат нарын тавьсан асуултад Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Даваасүрэн, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Даваасүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан, мөн зөвлөлийн гишүүн Л.Отгонтуяа, Н.Ууганбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа, С.Тэгшжаргал, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Д.Пүрэвдаваа, С.Эрдэнэбат нарын тавьсан асуултад Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Даваасүрэн, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 39 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Монгол Улсын нэгдсэн төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Даваасүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан, мөн зөвлөлийн гишүүн Л.Отгонтуяа, Н.Ууганбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа, С.Тэгшжаргал, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Төслийн анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, Ж.Батжаргал, Х.Ганхуяг, Б.Мөнхсоёл, Х.Булгантуяа, П.Сайнзориг, Г.Ганбаатар нарын тавьсан асуултад Төсвийн байнгын хорооны дарга Н.Наранбаатар, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Даваасүрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргав.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20

Татгалзсан: 19

Бүгд: 39

51.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.

Хамтарсан хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 58 минут үргэлжилж, 56 гишүүнээс 39 гишүүн хүрэлцэн ирж, 69.6 хувийн ирцтэйгээр 11 цаг 52 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН

ХОРООНЫ ДАРГА

Н.НАРАНБААТАР

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН

ХОРООНЫ ДАРГА

Б.ЗАЯАБАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН

БАЙГУУЛАХ ГАЗРЫН

ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

ТӨСВИЙН БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Наранбаатар: Ирц хүрсэн тул хурлаа эхэлье. Ирцэд орсон гишүүд танхимд орж ирээрэй. Байнгын хороодын эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 51,8 хувьтай бүрдсэн тул 2026 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн хамтарсан хуралдаан нээснийг мэдэгдье.

Хамтарсан хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026 оны 5 дугаар сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/

2.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2026 оны 5 дугаар сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

3.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё. 1 дэх асуудал.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Хэлэлцэж эхлэхээс өмнө Дэгийн тухай хуулийн дагуу хуралдаанд ирсэн гишүүдийн ирцийг овог нэрээр нь танилцуулна.

Норовын Алтанхуяг, Хөххүүгийн Болормаа, Хассуурийн Ганхуяг, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан, Чинбатын Номин, Ганзоригийн Тэмүүлэн, Дашцэрэнгийн Энхтүвшин, Нацагдоржийн Батсүмбэрэл, Ганзоригийн Лувсанжамц, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Ренчиндоржийн Батболд, Хүрэлбаатарын Булгантуяа, Цэрэнпилийн Даваасүрэн, Баатаржавын Мөнхсоёл, Даваахүүгийн Пүрэвдаваа, Банзрагчийн Түвшин, Доржсүрэнгийн Үүрийнтуяа, Пүрэвийн Батчимэг, Мэндбаярын Мандхай, Мөнхчулууны Энхцэцэг, Жигжидийн Батжаргал, Жамбалын Ганбаатар, Батжаргалын Заяабал, Нанзадын Наранбаатар, Пүрэвжавын Сайнзориг, Даваагийн Цогтбаатар, Отгоншарын Батнайрамдал, Шинэбаярын Бямбасүрэн, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Сүхбаатарын Эрдэнэболд нарын гишүүд ирсэн байна.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Жадамбын Энхбаяр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Загджавын Мэндсайхан Сангийн сайд, Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, Содномдаржаагийн Даваасүрэн Эдийн засаг, хөгжлийн дэд сайд, Лангааны Отгонтуяа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Нинжбатын Ууганбаяр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Батхишигийн Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалт бодлогын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Батжаргалын Төгөлдөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг та бүхэнд тараасан.

Хуулийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Нэрсээ өгье. Дэд сайд ирсэн юм уу. Дэд сайд ирсэн байна. Энхбаяр сайд ирж байгаа юу. 5 номер хариу тайлбар хэлээдэх дээ.

С.Даваасүрэн: Энхбаяр сайд Ерөнхий сайдтай хамт хойд бүсэд ажилласан. Тэгээд одоо яг Дарханаас наашаа ирж байгаа.

Н.Наранбаатар: Эрдэнэбат гишүүнийг асуултад нэмье. Өшөө асуулт асуух гишүүд байна уу. Эрдэнэбат гишүүнийг нэмээд, Эрдэнэбат гишүүнээр тасаллаа. Пүрэвдаваа гишүүн асуулт асууя.

Д.Пүрэвдаваа: Өглөөний мэнд хүргэе. Би нэг л зүйл тодруулах гээд байгаа. Санхүүгийн бөгөөд эдийн засгийн хувьд нөлөөллийн талаар тайлбарлаж өгөөч ээ. Ялангуяа энэ төсвийн хүрээний мэдэгдэлтэй уялдаад дагасан хууль буюу Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай гээд 7.5-ыг өөрчилж байгаа тийм үү. Энэ 7.5-ыг өөрчилснөөрөө төсөл, төсвийн тодотгол гэснийг хассугай гэж орж ирж байгаа юм. Энэ өөрчлөлтийг оруулснаараа Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн зорилго чинь өөрөө жоохон гажчих юм биш үү. Тэрэнд эдийн засгийн хувьд хэр их нөлөөлөл үзүүлэх юм. Дээрээс нь тухайн санхүүгийн жилийн хувьд бид нар тодотгол оруулах, хэдэн ч удаа тодотгол оруулах тэр үүд хаалгыг нээж байна л гэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ дээр санхүүгийн үр өгөөжийн асуудал, ялангуяа улсын төсөвтэй холбогдуулаад тэр дээр хийсэн судалгаа байдаг уу. Тооцоолол байна уу. Тэрийгээ танилцуулаач. Тэгээд дараа нь тодруулъя.

Н.Наранбаатар: Дагасан хууль чинь уг нь дараагийн асуудал байхгүй юу. Тийм хүрээ болон дагасан хууль гээд 2 асуудал байгаа. Зөвхөн хүрээ. Батнайрамдал гишүүн асуулт асууя.

О.Батнайрамдал: 2027 оны төсвийн хүрээ хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн хэлэлцүүлэг хийж байна л даа. Тэгээд Энхбаяр сайд байх хэрэгтэй байна. Энхбаяр сайд хэрвээ байхгүй бол Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга байх ёстой. Ер нь Улсын Их Хурал, Засгийн газрыг холбож байдаг үндсэн субъект чинь Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга шүү дээ. Тэр хүнийг

би л лав ерөөсөө Байнгын хороо дээр асуултад хариулж байгааг би ерөөсөө харсангүй шүү. Тэр олон өрөөтэй, 2 давхартаа нуугдаад байдаг юм уу хаашаа юм. Энэ гарч ирээд асуултдаа хариулах хэрэгтэй шүү дээ.

Миний асуулт Оюутолгой асуух гэж байсан. Ерөнхий сайдаас гаргасан Оюутолгойн асуудал дээр ажлын хэсэг гарсан байна лээ. Ахалж байгаа хүн нь Баттөмөрийн Энхбаяр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Монгол Улсын сайд ахалж байгаа. Тэгэхээр энийг сонсож байгаа олон нийт, дээрээс нь бас сэтгүүлчдэд хандаж хэлмээр байгаа юм. Оюутолгой дээр бид нар хариуцлагыг Энхбаяр сайдаас нэхнэ шүү. Яагаад гэвэл ажлын хэсэг ахалж байгаа байхгүй юу. Ажлын хэсэг ахалж байж өөрөө ирж хариулахгүй, Байнгын хороо дээрээ ирж гишүүдийнхээ асуултад хариулахгүй ингэж болохгүй шүү дээ. Одоо Энхбаяр сайд байхгүй юм чинь. Би ганцхан статистик хэлье. Миний гарт Morgan Stanley дэлхийн хамгийн том хөрөнгө оруулалтын банкны Оюутолгой дээр Рио Тинто дээр гаргасан 3 сарын өмнө гаргасан судалгаа байна. Morgan Stanley энэ судалгаагаар Оюутолгойн нийт үнэлгээг 35,7 тэрбум доллароор үнэлсэн байна. Оюутолгой төслийг 35,7 тэрбум доллароор 100 хувь үнэлсэн байгаа юм. 35,7 тэрбум доллар гэдэг бол Монголын нийт өнөөдрийн эдийн засгаас 43 хувиар том үнэлгээ шүү дээ. Тэрний 34 хувьд оногдох нь 12 тэрбум доллар байхгүй юу. Тэгэхээр Монголын эзэмшиж байгаа 34 хувь өнөөдрийн Morgan Stanley хийсэн тооцооллоор 12 тэрбум долларт үнэлэгдэж байгаа юм. Гэтэл бид нар 5 хувийн АМНАТ, татварууд нь бүгд маргаантай. Бид нарын авч байгаа өгөөж ийм л байгаа байхгүй юу.

Дахиад ганцхан статистик хэлье. 2026 онд шүү. Энэ жилдээ Ганбаатар сайд та Уул уурхайн сайд байсан. Та бас яг сайн мэдэж байгаа. 2026 онд Оюутолгой Morgan Stanley-н тооцооллоор 5,2 тэрбум долларын мөнгөн урсгалтай гарна гэж байгаа. 5,2 тэрбум долларын эерэг мөнгөн урсгал. Эерэг мөнгөн урсгал гэдэг бол ноогдол ашиг тарааж болох хэмжээний мөнгө гэсэн үг байхгүй юу. Тэр 5,2 тэрбум долларын Монголд оногдох 34 хувь нь 1,7 тэрбум доллар буюу 6 их наяд төгрөг. 6 их наяд төгрөг. Өнөөдөр бид нар 5 жил ярин байж хамгаалан байж ирээдүй .../минут дуусав/

Н.Наранбаатар: 1 минут нэмж өгье.

О.Батнайрамдал: Өнөөдөр бид нар баялгийн сандаа 6 их наядыг төвлөрүүлсэн. Оюутолгойг 2026 онд эерэг мөнгөн урсгалын 34 хувьд оногдох хэмжээний мөнгө нь ганцхан жилийн дотор 6 их наяд буюу ирээдүй өв сантай тэнцэх хэмжээний. Харамсалтай нь бид нар эндээс 1 ч төгрөг авахгүй. 1 ч төгрөг авахгүй ийм байдалтай байгаад байгаа юм. Тэгэхээр одоо би дэд сайдаас нь асуучихъя. Даваасүрэн дэд сайд байна. Ажлын хэсэгт орсон байна лээ. Энэ дээр та яг энэ тоон дээр дүгнэлт хий дээ. Та эдийн засагч хүн. Оюутолгой 5,2 тэрбум долларын ашигтай 2026 онд ажиллах нь. Гэтэл бид нар өнөөдөр төсвийн цоорхойгоо нөхөх талаар ярьж байгаа юм. Энэ дээр таны хувийн дүгнэлт юу байгаа юм. Эдийн засагчийн хувьд дүгнэлт юу байгаа юм. Ажлын хэсгийн гишүүний хувьд яг юу байгаа юм. Та яг энэ дээр эдийн засагчийн хувьд тодорхой байр сууриа хэлээдэх.

Н.Наранбаатар: Дэд сайд хариулна. 5 номерын микрофоныг нээе.

С.Даваасүрэн: Батнайрамдал гишүүний асуусан асуултад тайлбар хэлье. Оюутолгойн ажлын хэсгийн хувьд бол менежментийн төлбөрийг бууруулах ажлын хэсэгт орж ажилласан. Яг ажлын хэсгийн даалгаврыг бол Засгийн газрын хуралдаанаар баталсан тэр даалгаврын дагуу ажилласан. Тэгээд яг энэ даалгаврынхаа хүрээнд ажлын хэсэг бол амжилттай ажиллаж, өгсөн даалгаврыг

бол биелүүлсэн. Тэр нь манай талын төлөх төлбөрийн хэмжээг 2 дахин бууруулах ийм даалгавар байсан. Тэрийг бол хийсэн. Өнөөдрийн төсвийн хүрээг ярилцаж байгаа энэ хүрээнд бол Оюутолгойн экспортыг зэсийн баяжмалын хувьд бол 2027 онд 1 сая 485 мянган тонн баяжмалыг бол экспортлохоор энэ төсвийн хүрээнд төлөвлөгдөж байгаа. Үүнээсээ болохоороо зэс нь үндсэндээ 31 хувь, алт нь 6,6 хувь гэсэн агууламжтайгаар. 2028 онд бол энэ хэмжээ мөн адил 1 сая 446, 2029 онд 1 сая 497 гээд агууламжийн хувьд бол бас өөрчлөлтгүй, 30 гаруй хувийн зэсийн агууламжтай, алтны агууламжийн хувьд бол 6 хувьтай байгаа. Тэгэхээр өнөөдрийн энэ хэлэлцүүлж байгаа асуудал бол 2027 оны төсвийн хүрээ, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай ийм асуудал байгаа юм. Тэгэхээр .../минут дуусав/

Н.Наранбаатар: Батнайрамдал гишүүн тодруулъя.

О.Батнайрамдал: 1 зүйлийг хэллээ. Бас наадах чинь надад сонин санагдлаа шүү. Менежментийн төлбөрийг 2 дахин бууруулах даалгавар авсан гэнэ үү. Даалгавар чинь 2 дахин бууруул гэж анхнаасаа өгсөн юм уу. 2 дахин бууруул гэдэг даалгавар яг байсан уу. Тэндээс цаашаагаа явахгүй гэсэн ийм даалгавар байсан юм уу. Та наадхаа бодож байгаад дахиж хариулаарай.

2 дугаарт харин ингээд гөлөг төөрүүлж байгаа юм шиг ийм юм сонсмооргүй байгаа юм. Менежментийн төлбөрийг 50 хувь бууруулсан. Сайн хэрэг. Гэхдээ ач холбогдлын хувьд Монголд ерөөсөө орж ирэх мөнгөн урсгалын ач холбогдлын хувьд л авах ёстой байхгүй юу. Менежментийн төлбөр 50 хувь бууруулна гэдэг бол 70 сая доллар хэмнэж байгаа юм. 70 сая доллар бол өдөр болгон төлж байгаа 15 тэрбумын 4,5 хувьтай тэнцэхүйц үр дүн шүү. 4,5 хувьтай тэнцэх. Тэгэхээр зээлийн хүү хаана байна. Онтре-н хэлцэл хаана байна. 120 дугаар тогтоол хаана байна. 120 дугаар тогтоолд менежментийн төлбөр ороогүй. Яагаад гэвэл ач холбогдлын хувьд дэндүү жижигхэн учраас оруулаагүй байсан юм. Одоо менежментийн төлбөрөөс өөр юм .../минут дуусав/

Н.Наранбаатар: 5 номер.

С.Даваасүрэн: Тэгэхээр Батнайрамдал гишүүний асуултад хариулъя. 3 үндсэн ажлын хэсэг байгаа. Энэ нь болохоор 1 дүгээрт зээлийн хүүг бууруулах, 2 дахь нь менежментийн төлбөрийг 50 хувь бууруулах, 3 дахь нь болохоор Онтре-н гэрээ хэлэлцээртэй холбоотой. Тэгэхээр миний хувьд менежментийн төлбөрийг бууруулах тэр ажлын хэсэгт бол ажилласан. Тэгэхээр бусад ажлын хэсгийн хувьд бол ажил нь явагдаж байгаа байх. Тухайн ажлын хэсгийн бүрэлдэхүүн ахлагчдаас нь асуух нь зөв байх.

Н.Наранбаатар: Эрдэнэбат гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэбат: 1 дүгээрт энэ инфляцыг нэлээн өөдрөгөөр л төсөөлж харагдаж байна. Яг үүний өмнөх, өмнөхийн 2025, 2026 онд бас яг иймэрхүү байдлаар л оруулж ирж байсан. Энийг чинь дагаад төсвийн мэдэгдлүүд бол орж ирнэ. Төсөв орж ирэхдээ яадаг вэ гэхээр нөгөө цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж, бусад зүйлүүдийг яг энүүгээр чинь бариад л тавьдаг. Гэтэл яг түрүү жил та бүгд маань инфляцыг 7 хувь байна гэж байсан. Одоо яг хэдтэй байгаа билээ. Үүний гол шалтгаан нь юу байгаа юм гэдгийг бол асуумаар байна.

2 дугаарт өнгөрсөн 7 хоногт Монгол банк дээр очихоор инфляц 2 оронтой тоон руу шилжсэн. Ерөөсөө гуравхан бүтээгдэхүүнийг голлож нэрлэсэн. Мах, төмс,

дизель түлш гээд. Та бүгд болохоор цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж нэмэхээр л инфляц тавиад туучихна. Пүү паа гээд байсан. Яг ний нуугүй хэлэхэд бол инфляцын чинь гол хүчин зүйлүүд нь өөр асуудалд байгаад байна шүү дээ. Нийлүүлэлт, хангалт зохион байгуулалт, яах вэ тэр түлшийг бол ойлгож болох юм. Геополитикийн асуудал гээд. Тийм учраас манай Мөнгөний бодлогын тогтвортой зөвлөл ч гэсэн тэр, манай Засгийн газар ч гэсэн тэр ерөөсөө энэ инфляцыг юу гэж тайлбарлаж ирсэн бэ гэхээр энэ түвшинд л барихыг зорино гэдэг. Үүний хохирогч нь хэн болоод байна вэ гэхээр үүний дараа төсөв дээр орж ирэхдээ инфляц 7 хувьтай байгаа юм чинь 7 хувиар гэдэг байдлаар л орж ирэх байх л даа.

Гэтэл Эдийн засаг, хөгжлийн сайд өнгөрсөн 7 хоногт юу гэж мэдэгдсэн бэ гэхээр тэтгэврийн нэмэгдлийн асуудал 3,2 орчим хувиар бол хоцорч байгаа буюу инфляцаа гүйцээгүй гэж хэлсэн. Тэгэхээр үүний чинь хохирогч нь нөгөө жирийн ард иргэд л болоод байна л даа. Тийм учраас энэ инфляцыг та бүгд маань яаж тооцож, 2029 он гэхэд бол 5 хувь руу оруулна гэж байгаа юм. Гэтэл гадаад, дотоод нөхцөл байдал гэдэг юм уу энэ зүйл чинь бол амаргүй байгаа. Бид нар өөрөө хамгийн их өөрсдөө үйлдвэрлэж чаддаг махаа ч гэсэн барьж чадахгүй байна шүү дээ. Энийг яах юм ер нь цаашдаа. 1 талд нь бол яах вэ, махны үнэ өсөх нь бол малчдад сайн гээд байдаг. Гэтэл яг үнэндээ малчдын гар дээр байгаа мах чинь өсөөгүй юм байна лээ. Яг бодит байдал дээрээ. Тийм учраас энийгээ зохицуулах юм хийхгүй бол инфляцыг чинь ийм бага түвшнээр тооцчихонгуут ард нь энийг нь индексжүүлэх олон юмнууд хүлээж байгаа учраас бол тэнд байгаа хүмүүс чинь л хохирч л байна л даа. Тэгэхээр энэ тал дээр бол би 1 дүгээрт тайлбар авъя.

2 дугаарт нөгөө том том ордуудынхаа нөгөө эдийн засагт төр рояльтигаар авна гээд байсан энэ юунууд ер нь юу болж байгаа вэ. Авах юм уу, авахгүй юм уу. Авах ёстой татвараа болон төрд авах ёстой тэр ноогдол ашгуудаа хэзээ авах юм бэ. Өдөрт л хэдэн зуун тэрбумаар тоологдож байгаа гэж би бол ойлгоод байгаа шүү дээ. Энэ тал дээр бол та бүгдээс асуумаар байна.

Н.Наранбаатар: 5 номерын микрофон.

С.Даваасүрэн: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр инфляцын хувьд бол төсвийн хүрээн дээр 2027 ондоо 7 хувь байна. 2028, 2029 онд 6, 5 хувьтай байна гэсэн ийм төсөөлөл хийсэн байгаа. Тэгэхээр инфляц гэдэг бол ер нь макро эдийн засгийн их чухал үзүүлэлт. Тэгэхээр инфляцыг хэр түвшинд барьж, хүлээж байна вэ гэдгээс ер нь эдийн засагт иргэдийн хувьд, аж ахуйн нэгжүүдийн хувьд бүх төрлийн хүлээлт нь бас өөрчлөгдөж байдаг.

Инфляцын түвшнийг тооцохдоо Монголбанкны бодлогын зорилтот түвшинтэй бас уялдуулж тооцсон байгаа. Энэ нь ирэх онд бол 6 дээр +2 буюу багадаа 4, ихдээ 8 байна гэсэн энэ үзүүлэлтийг бас ашиглаж тооцсон байгаа. Үүний цаад талд бол үзүүлэлтийг тооцохдоо хүнсний болон хүнсний бус инфляцаар, мөн эдийн засагт бий болоод байгаа эдийн засгийн тэлэлтийн нөлөө гээд их олон хүчин зүйлүүдийг бол энд тооцож үзсэн.

Өнгөрсөн оны хувьд бол үндсэндээ Монголбанкны зорилтот түвшинд хадгалагдсан. Оны эцэст инфляцын түвшин 7,5 хувьтай байсан. Энэ оны эхний 3 сарын байдал дээр ч гэсэн үндсэндээ Монголбанкны зорилтот түвшинд бол байсан. Харин 4 дүгээр сараас инфляцын түвшин 10,1 хувь болж өссөн. Ингэхдээ хүнсний инфляц бол харьцангуй өндөр, үүн дотор мах, мөн ногоо, тэгээд зарим гурилан бүтээгдэхүүний үнэ бол өссөн байгаа. Гэхдээ цаашдаа энэ өсөлт нь болохоор

ялангуяа хүнсний бус бүтээгдэхүүн тэр дотроо дизель дотор энэ тогтвортой байдлаар үнийг хадгалах ийм боломж бий болж байгаа. Махны үнийн хувьд бол ирэх саруудаас эхлээд харьцангуй буурах ийм хүлээлттэй байгаа. Энэ нь бол юу вэ гэхээрээ инфляцын түвшин энэ зорилтот түвшинд хадгалах ийм орон зай бий болно гэж харж байгаа.

Н.Наранбаатар: 2 дахь асуудал тэр төрийн эзэмшлийн хувьтай холбоотой асуулт асуусан шүү дээ. Хариулах хүн байхгүй юу. Бичгээр хариу өгнө шүү. Эрдэнэбат гишүүн тодруулъя.

С.Эрдэнэбат: Тэгээд ийм чухал төсвийн асуудал ярьж байхад төсөвт орж ирэх орлогыг хэрхэн ямар явцтай байгаа юм гэдэг тал дээр хариулт өгөх хүнгүй байна гээд байгаа. Би бол Сангийн яам, бусад тэр орд газруудтай, байгууллагуудтай хэлэлцээр хийж байгаа хүмүүс энэ дотор байгаа гэж би ойлгоод байгаа шүү дээ.

2 дугаарт энэ төсөв дээр маш олон тендерүүд энэ үнэ, инфляцаас болоод бас дахиад баахан нэмэлт зардлууд нэхээд суучихсан байгаа юм байна лээ. Тэгээд энийг ер нь яах юм бэ. Та хэд ингээд зардлын дээд хязгаар гээд баахан юм оруулж ирээд байдаг. Урсгал зардлын дээд хэмжээ гэж оруулж ирээд байдаг. Гэтэл энэ хөрөнгө оруулалтууд чинь өөрсдөө ер нь хэр үр өгөөжтэй байгаа юм бэ. Эргээд яг ний нуугүй хэлэхэд баахан валютаа гадагшлуулдаг, гаднын ажиллах хүчийг авч орж ирээд гадаадаас баахан импортын бараа бүтээгдэхүүн оруулж ирээд тэгээд зарим нь бол цаасан дээр голдуу зарим компаниуд нь орж ирээд, эргээд эдийн засагтаа шингэж өгдөггүй, жижиг дундуудаа дээш нь татдаггүй ийм л юм яваад байгаа. Тэгэхээр энэ тал дээр би асуумаар байна.

Н.Наранбаатар: 5 номерын микрофон.

С.Даваасүрэн: Эрдэнэбат гишүүний асуултад нэмж хариулъя. Энэ дээр төсвийн хүрээний хувьд бол яг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасны дагуу гол 9 үзүүлэлтийг бол оруулж ирж байгаа. Энэ дээр тэнцвэржүүлсэн орлогын дээд хэмжээ, мөн нийт зарлагын дээд хэмжээг бол яг тогтоож оруулж ирж байгаа. Тэгэхээр уул уурхайн салбар, ялангуяа уул уурхайн экспорт давамгайлсан тэгээд гадна зах зээлээс үнэ ханшийн өөрчлөлтөөр бас эдийн засаг савладаг энэ улсуудын хувьд бол яг энэ тэнцвэржүүлсэн орлогын дээд хэмжээ, зарлагын дээд хэмжээ, тэнцвэржүүлсэн тэнцлийг бол тооцдог ийм жишиг байгаа. Яг үүний дагуу төсвийн хүрээний төсөөлөл дээр энэ тооцооллыг хийж оруулж ирсэн байгаа. Таны асуусан үлдсэн задаргааны хувьд бол Сангийн яамнаас хариулах боломжтой.

Н.Наранбаатар: 8 номер нэмж хариулъя.

Ж.Дэлгэржаргал: Гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал. Хөрөнгө оруулалтуудын хувьд бол энэ жил улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 738 төсөл хэрэгжиж байгаа. Үүний 296 нь бол шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтууд. Одоо яг шинээр хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалтуудын гэрээ байгуулах явц, байгуулсан хувь бол 55 хувьтай байгаа. Үлдсэн төсөл арга хэмжээ бол шилжих хөрөнгө оруулалтууд буюу энэ онд ихэнх нь дуусах. Энэ утгаараа ихэнх гүйцэтгэл нь өмнөх онуудад гарчихсан байгаа. Нийт 1 төслийн гэрээний үнийн дүнгийн ер нь 85 хувь нь бол бүтээн байгуулалт руу ордог зардал байдаг. Энэ 85 хувь дотроо бол 43 хувь нь материалын зардал байдаг. Тэгээд 43 хувь дотроо мэдээж импортын хамаарал бол мэдээж өндөртэй. Тэгэхээр хөрөнгө оруулалтуудын хувьд бол

төсвийн хуулийн шаардлагын дагуу шинээр сүүлийн жилүүдэд хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтууд сүүлийн 2 жилийн шинэчилсэн зураг төсөвтэй явж байгаа.

Дээрээс нь яг энэ төсөвт өртөг гэрээний үнийн дотор бол яг хувийн хэвшил өөрөө эрсдэлээ хариуцаад, ашгийн 15 хувь явдаг .../минут дуусав/

Н.Наранбаатар: Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдааны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Заяабал танилцуулна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

10.17 цаг.

2 дахь асуудал.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Жадамбын Энхбаяр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Загджавын Мэндсайхан Сангийн сайд, Энхбаяр сайдын оронд дэд сайд Даваасүрэн, Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, Содномдаржаагийн Даваасүрэн Түрүүн танилцуулчихсан. Лангааны Отгонтуяа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Нинжбатын Ууганбаатар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Чойгүнсэнгийн Чимидсүрэн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг та бүхэнд тараасан. Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Эрдэнэбат гишүүнээр тасаллаа. Жамбалын Ганбаатар гишүүн асуулт асууна. Тэгвэл дараагийн асуудал дээр асууна. Норовын Алтанхуяг гишүүн асуулт асууна.

Н.Алтанхуяг: Та бүхний өглөөний агуулгыг айлтгая. Нэлээн олон хоног энийг ярилаа л даа. Тэгээд Засгийн газраас орж ирж байгаа энэ юм үндсэндээ тоонууд нь өөрчлөгдсөнгүй, бодлого нь өөрчлөгдсөнгүй. Тэгээд нэгэнт яах вэ ингээд батлагдах гэж байгаа юм бол надад ямар асуулт байгаа вэ гэхээр та нарын энэ оруулж ирээд зүтгүүлээд, батлуулж байгаа энэ юмнаас бас ямар эерэг үр дүн гарах

юм. Улс орны санхүүгийн салбарт, эдийн засгийн салбарт, ард иргэдэд хэрэгтэй юм юу болох юм бэ. Энэ асуултад хариулаад өгөөч. Бид нар баахан тоо яриад л, баахан юм батлаад л, хасаад л, ярилцаад баталсан болдог. Тэгээд энэ ямар үр дүнд хүрэх юм. Би тэгээд дахиад тодотгож асууна. Энэ хууль батлагдсанаар яг ийм, ийм юм болно. Ийм мундаг юм болно гэдгээ тайлбарлаадхаач. Одоо батлагдаж байгаа учраас би асууж байгаа шүү.

Н.Наранбаатар: Дэд сайд 5 номер.

С.Даваасүрэн: Алтанхуяг гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр ер нь өнгөрсөн хугацаанд эдийн засаг дахь төрийн оролцоо төсвийн тэлэлтээр дамжаад нэлээд нэмэгдсэн. Тэгэхээр 2027 он, 2028, 2029 оны төсвийн хүрээ, төсвийн төсөөлөл дээр авч явж байгаа баримталсан үндсэн зарчим юу вэ гэхээр нийт төсвийн орлогын эдийн засаг, тэр дундаа ДНБ-д эзэлж байгаа хувь хэмжээг үе шаттай бууруулах энэ бодлогыг бол баримталж байгаа. 2027 оны төсвийн хувьд бол ДНБ-д эзлэх хувь нь 30,4 хувьтай байгаа бол 2028 онд 29, 2029 онд 28 хувь болгож ингэж бууруулах энэ тооцооллыг хийж байгаа. Мөн зарлагын хэмжээ бас адилхан. Зарлагын хувьд бол ирэх онд энэ оны эхнээс нийгмийн салбарт багш, эмч нарын цалинг нэмэгдсэнтэй холбоотойгоор төсвийн зарлага бол нэмэгдэж байгаа. Тэгэхээр энэ зарлага ирэх 2027 ондоо бол ДНБ-ий төсвийн нийт зарлагын хэмжээ 31,9 хувьтай, харин 2028 онд 30, 2029 ондоо 28 хувьтай байлгах. Энэ нь юу гэж хэлж байна вэ гэхээр яг таны асуусан эдийн засаг болон санхүүгийн салбарт Засгийн газар, төрийн оролцоо төсөв, санхүүгийн бодлогоороо дамжаад энэ оролцоог аль болох бууруулах гэсэн энэ л үндсэн зарчмыг баримталж байгаа. Ингээд дээр нь инфляцын түвшнийг илүү тогтвортой 7, 6, 5 гэсэн хувьд барих ийм бодлогыг бол баримталж байгаа.

Н.Наранбаатар: Алтанхуяг гишүүн тодруулъя.

Н.Алтанхуяг: Асуулт биш шүү дээ. Би 1 санал хэлчихье дээ. Та нар маань ингээд баахан л ажил удаад, Их Хурал дээр ажил удаад, Засгийн газар нэг их юм хийж байгаа царайтай юм оруулж ирээд. Тэгээд түрүүн өөрийн чинь уншиж байгаа инфляц энэ тэр бол 2 оронтой тоо руу гараад явчихсан. Энэ ард түмний ахуй амьжиргаа ерөөсөө бид нар мянган цаас, мянган хууль, мянган тогтоол батлаад ерөөсөө дээшилдэггүй уруудаад байдаг. Энэ хажууд чинь зэрэгцээд суучихсан Төсвийн тогтвортой байдлын нөхдүүд мэргэжлийн үүднээс энэ энийгээ ингээд өөрчилчих гэхээр нь үгүй дээ ингэж батлахаар сайжирна гээд байх юм. Одоо тэгээд та нарын оруулж ирснээр, Засгийн газрын оруулж ирснээр МАН-ын бодлогоор ард түмний ахуй амьжиргаа дээшилдэг бол энэ 10 хэдэн жил дээшлэх боллоо. Гадаадын зээл тусламжаа хүртэл нэмэгдүүлээд, Их Хурлын гишүүдээ хүртэл өргөн бариулаад .../минут дуусав/

Н.Наранбаатар: Гүйцээгээд асуучихъя.

Н.Алтанхуяг: Энийг жаахан анхаараад өгмөөр байх юм даа. Хэлэхээр хэлсэн болох, хэлэхгүй болохоор улам уруудан доройтох, унах, сүйрэх ийм юм руу яваад байх юм. Би энгийн юм асуугаад байна шүү дээ. Та нарын оруулж ирснээр бүгдийг нь батлаад явууллаа. Засгийн бодлогыг нь яг энэ чигт нь хийгээд, дэмжих нь дэмжээд, дэмжихгүйг нь хүчиндээд гаргаад байгаа байхгүй юу дандаа. Үгүй ээ, тэгээд ард түмний ахуй амьжиргаа яаж дээшилж байгаа юм. Махныхаа үнийг хүртэл зохицуулж чадахгүй, дандаа зөрчилтэй юм ярина. Махны үнэ зах зээлийн үед зохицуулж болдоггүй юм гэж нэг хэсэг нь солиорно. Нөгөө хэсэг нь 2500 тонн мах

хааччихсан юм гэж хайна. Ийм зөрчилтэй байдалтай энэ улс орон явахгүй дээ. Бодлого ч явахгүй байна.

Би тэр боловсролын салбар дээр бас хэлье. Танай Сангийн яам хариуцлага хүлээх ёстой байхгүй юу. Багш нарын цалин нэмэхтэй холбоотой асуудал дээр би Сангийн сайд байсан хүн. Огт оролцохгүйгээр явна гэж байхгүй. Тэгээд 1 сайдыгаа ингээд золигт гаргана. Тэр муу сайд болсон учраас ингэсэн юм. Ийм юмнаасаа болиод өгөөч ээ. Ажлаа .../минут дуусав/

Н.Наранбаатар: 5 номер хариулъя. Пүрэвдаваа гишүүн асуулт асууя.

Д.Пүрэвдаваа: Өглөөний мэнд. Би хэд хэдэн зүйлийг асууя гээд байгаа юм.

1 дүгээрт эхлээд энийг тайлбарлаж өгөх нь зүйтэй байх. Хурлын тэмдэглэлд бас тусгамаар байна. Байнгын хороон дарга аа, Байнгын хороон дарга аа анхааръя. Эдийн засгийн байнгын хорооны дарга, Төсвийн байнгын хороон дарга аа бид нар аягүй том ухралт хийж байгаа юм шүү. Энэ төсвийн хүрээний мэдэгдэл гээд дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл гэдгийн гол учир нь жил болгон өргөн баригддаг улсын төсөв, дээрээс нь тодотгол өргөн барьдаг. Энэ 2 хоорондоо зайтай байх тусмаа улс төржсөн, ялангуяа энэ амьдралгүй төсөв батлахаас л урьдчилан сэргийлж байгаа төсвийн сахилга батыг сахиулж байгаа ийм л бичиг баримт байхгүй юу даа. Хязгаарууд, тоон хязгаарууд.

Гэтэл энэ 7.5-д төсөл, төсвийн тодотгол гэснийг авч хаяя гэж байгаа юм. Тэгэх юм бол бид нар яг төсөв батлахынхаа өмнө дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлээ баталдаг болчих юм бол зүгээр л төсөвтөө тааруулаад л хүрээгээ баталдаг болно гэсэн үг. Одоо юманд жоохон шинжлэх ухаанч хандъя. Энэ төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбогдуулаад манай Төсвийн тогтвортой байдлын зөвлөл маань нэлээн л сайн эдийн засагч нар байдаг шүү дээ. Та бүхэн маань. Яамныхан маань улс төрждөг байх гэж бодъё. Тэгэхдээ энэ чинь ухралт биз дээ. Аль болохоор бид нар энэ төсөв батлах хугацаа, дунд хугацааны макро эдийн засгийн бодлого гэдэг зүйлээ ойртуулаад, хэдэн ч удаа юу гэдэг юм өөрчилж болохоор ингэж хуульчилж өгч байгаа нь бол маш том ухралт шүү дээ. Тэгээд та бүхэн маань энэ оруулж ирж байгаа юм чинь Эдийн засгийн яам, Сангийн яам санхүүгийн хувьд ямар өгөөж байгаа юм. Ямар алдагдал байгаа юм. Эдийн засгийн хувьд ямар өгөөж байгаа юм. Ямар алдагдал байгаа юм.

Би дахиад л хэлье. Өнгөрсөн төсөв батлахад 1,1 их наяд төгрөгийг зүгээр 2 нам зөвшилцөөд л Төсвийн байнгын хороогоор орж ирээд л хэлэлцээгүй, аудит хориг тавьчихаад байхад баталсан шүү дээ.

НӨАТ-ын асуудал байгаа. 1 сарын 1-ээс санхүүжих ёстой байсан НӨАТ-ын асуудлыг ганцхан үсэг өөрчлөөд л 10 сарын 1 болгосон. Энэ бол эрүүгийн зүйл, заалтаар бол урьдчилж төлөвлөж байгаад залилан мэхлэх, хууран мэхлэх үйл ажиллагаа явсан шүү дээ. Та бүхэн тайлбарлачих. Би дараа нь асууя.

Н.Наранбаатар: 8 номер хариулъя.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж гишүүний асуултад хариулъя. Яг 7.5 гэдэг энэ заалт маань анх энэ дээр нэмэгдсэнээс хойш бол 7.5 гэдэг заалт маань өөрөө 2 удаа өөрчлөгдчихөөд байгаа юм. Дээрээс нь 7.6, 7.7 гээд яг энэ заалтад

хамаарахгүй шүү гэдэг бас 2 заалт орчхоод байгаа юм. Тэгэхээр энэ 4 удаагийн өөрчлөлт нь өөрөө юу байсан гэхээр зөвхөн тодотголтой холбоотой асуудал байсан.

1 дүгээрт тухайн үед шинэ Засгийн газар байгуулагдаад, Монгол Улсын Ерөнхий сайд маань өөрөө Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд засгаа байгуулсан чинь шинэ зарим яамнуудыг татан буулгах болсон чинь тодотгол хийж чадахаа больчихсон. Ийм асуудал болсон.

2-т нь бол яг тухайн жилийн төсөв өөрөө бас онцлогтой төсөв байгаад, алдагдалгүй төсөв байхаар зарлагаа бууруулах гээд ороод ирсэн. Орлого, зарлага хоёроо зэрэг бууруулах гэсэн чинь бас тодотгол хийж чадахгүй болчихсон. Нэг талаараа таны саналтай би 100 хувь санал 1 байгаа нь тухайн жилийн хүрээг баталчхаад ирэх жилийнхээ хүрээг баталчхаад ирэх жилийн төсвөө батлахдаа буюу энэ 3 сарын хугацаанд бол өөрчлөгдөхгүй байх гэдэг дээр бид нар 100 хувь санал 1 байгаад байгаа юм. Гол нь тодотголын асуудал маань өөрөө гэнэтийн асуудал байдаг. Тодотгол өөрөө дахиад төсвийн хуулийн 34 дүгээр зүйлээр 5 нөхцөл заачихсан байдаг. Энэ нөхцөлүүд хуулийн нөхцөл үүссэн тохиолдолд зөвхөн тодотгол хийдэг ийм хуультай.

Тэгэхээр энэ маань өөрөө дахиад гарах гэхээр өөрөө угаасаа тэр хуулийн босго маань их өндөр байгаад байдаг. Тэгэхээр энэ тэгж амархан тодотгол хийх тийм боломж ч байхгүй. Тухайн жилийн, ирэх жилийн төсвийн хүрээгээ бид нар 6 сарын 1-нд батлуулчхаад, 9 сарын 1-нд өргөн барихдаа хүрээгээ өөрчилдөг энэ бол харин болохгүй байна гэдэг агуулгаар бид харж байгаа. Одоо энэ хууль дээр өөрчлөлт орж байгаа нь бол яг энэ хэсэг нь үлдээд, намартаа дахиж хүрээгээ өөрчлөхгүй шүү гэдэг ийм агуулгаар орж ирж байгаа. Тэгэхээр зөвхөн тодотголын асуудал маань өөрөө цаг хугацааны хувьд та эдийн засгийн үр өгөөжийг асууж байна. Тодотголын ерөөсөө үр өгөөж, гол зорилго бол богино хугацаанд маневрлах л энэ гол зорилго байгаад байгаа юм. Тэгэхээр энэ зорилгоо хэрэгжүүлэх гэж энэ заалт оруулж ирж байгаа. Тэгээд Засгийн газрын хувьд энийг өмнө нь 4 удаа энэ заалт дээр өөрчлөлт оруулчихсан учраас 2023 онд батлагдсанаас хойшоо ингээд 4 удаа ийм өөрчлөлт орчихсон байгаад байгаа учраас энийг нэг мөр ойлгох, зөвхөн ирэх жилийн төсвийн хүрээ, ирэх жилийн төсөв дээрээ хамааралтай байхаар ингэж оруулж ирсэн байгаа. Баярлалаа.

Н.Наранбаатар: Тогтвортой байдлын зөвлөл хариулах уу. 1 номерын микрофон.

Ж.Дэлгэрсайхан: Дагалдах хууль дээр бид нар яг энэ хүрээнд дүгнэлтээ өгсөн. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7.5 гэдэг энэ заалт түрүү жилээс үйлчилж эхлэх байсан. Сая Санжаадорж даргын хэлж байгаа үнэн. 2 удаа энэ заалт бол төсвийн тодотголыг хязгаарласан. Тэгээд хязгаарласных нь дагуу бас өөрчилчихсэн. Тэгээд яг энэ заалтыг бидний хувьд харж байгаа нь ер нь төсвийн тогтвортой байдлыг хангуулах тэр чиг үүрэг дээр энэ заалт нэлээд ач холбогдолтой заалт байна. Дуртай үедээ төсөв тодотгоод байдаг нөхцөл байдлыг бид нар хязгаарлаж чадаж байгаа. Бодит байдал дээр энэ амьдрал харуулж байна гэж үзсэн. Тэгээд бид дүгнэлтдээ бол гарцаа байхгүй энэ заалтыг хийж байгаа нь бол ухралт гэдэг ийм үгийг бас ашигласан. Энэ бол дуртай үедээ төсөв тодотгох, төсвийн тогтворгүй байдал, төсвийн сайн төлөвлөлт гэдэг зүйл рүү бидний явж байгаа тэр чиг баримжаанд бас эсрэг нөлөө үзүүлэх юм байна. Илүү сайн төлөвлөж, тодотгодоггүй төсөв байх энэ бодлогоосоо л бид нар ухарч байна л гэж .../минут дуусав/

Н.Наранбаатар: Пүрэвдаваа гишүүн тодруулъя.

Д.Пүрэвдаваа: Эдийн засаг, хөгжлийн яамнаас асуумаар байна. Та бүхэн маань дунд хугацааны төлөвлөлт буюу 4-5 жилийг бид нар төлөвлөж чадахгүй байна гэсэн та нарын энэ өөрчлөлт оруулж ирж байгаа чинь л үүний илрэл биз дээ. Макро эдийн засгийн асуудал бол төсвийн хүрээгээрээ дунд хугацаандаа ингээд төсөөлөөд, 2-3 жилээр эдийн засгаа тооцоолоод, тоонууд дээр ажиллаад ингээд батлуулчхаж байгаа юм. Гэтэл Эдийн засаг, хөгжлийн яам өнөөдрийн үйл ажиллагаатайгаа уялдуулаад, мөрийн хөтөлбөртэйгөө уялдуулаад энийгээ тооцоолж чадахгүй байгаагийн л ажлаа дутуу хийж байгаагийн л илрэл учраас энэ хуульд өөрчлөлт оруулж байгаа шүү дээ. Энэ дээр та бүхэн маань няцаалтаа хийгээдэх дээ. Би дахиад асууя.

Н.Наранбаатар: 5 номер.

С.Даваасүрэн: Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр энэ дээр нөгөө үндсэн төсөв бол ямарваа нэгэн байдлаар өөрчлөгдөхгүй. Тэгэхээр энэ төсвийн тодотгол хийх шаардлагууд, нөхцөлүүд бол Төсвийн тогтвортой байдлын тухай хууль дээр бол байгаа. Тэгэхээр зайлшгүй нөхцөл үүссэн тохиолдолд хугацаа харгалзахгүйгээр өөрчлөлт хийх тухай асуудал л ярьж байгаа. Тэгэхээр 3 сар гэдэг бол богино хугацаа мэт боловч яг нөхцөл байдал хүндэрсэн үед бол их амаргүй хугацаа. Тийм учраас энэ 3 сар гэдэг тийм хатуу хугацааг бол зааж өгөх нь бас их зохимжгүй юм. Яг энэ хэмжээгээрээ зардал бол их өөрчлөгдөж байгаа. Тухайлах юм бол сая энэ 3 сард Ойрх Дорнодод үүссэн нөхцөл байдал гэхэд өнөөдөр бол 2 сарын хугацаа болж байна. Тэгэхээр түлш шатахууны үнэ яаж их өөрчлөгдөж байгаа нь бол эндээс харагдаж байгаа. Тэгэхээр тодотгол хийхдээ 3 сар гэсэн хугацааг бол заахгүй байх гэдэг л .../минут дуусав/

Н.Наранбаатар: Пүрэвдаваа гишүүн тодруулъя.

Д.Пүрэвдаваа: Эдийн засаг, хөгжлийн яам худлаа яриад байна. Ер нь бол зүгээр дундаж компани зүгээр зах зээл дээр өнөөдөр Монголд бүр Дэлхийд больё гэж бодоход дундаж манай компаниуд жилийнхээ төсвийг ер нь бол таамаглаж чадаж байгаа. Үйл ажиллагааг таамаглаж байгаа, санхүүгийн төлөвлөгөөгөө таамаглаад. Энгийнээр зүйрлэвээс юу гэдэг юм Мобиком ч гэдэг юм уу, Юнител ч гэдэг юм уу хэрэглэгчид нь тодорхой, үйл ажиллагаа нь тодорхой, жил болгон давтагддаг зүйл. Дайнаас үүдэлтэй хэд хэдхэн л параметрууд өөрчлөгдөж байгаа шүү дээ. Үүнээс үүдэлтэй тэр асуудлуудаа л юу гэдэг юм залруулах байх. Та бүхэн маань бүхэл бүтэн улс байж байж ийм юм яриад, 3 сар гэдэг бол байнга юм өөрчлөгддөг. Тэгээд дээрээс нь макро эдийн засаг өөрчлөгддөг ийм юм ярина гэдэг бол утгагүй шүү.

Н.Наранбаатар: Санал хэллээ. Эрдэнэбат гишүүн асуулт асууна.

С.Эрдэнэбат: Та хэдэд бас нэг зүйлийг хүсмээр байна. Багш, эмчийн цалин нэмчихсэн учраас бүх юм болохоо байчихлаа гэдэг энэ яриагаа жоохон болимоор байна. Энэ чинь бидний хийх ёстой ажил. Хийсэн Засгийн газар бас төсвийнхөө боломжуудыг дайчлаад, тэгээд яг ний нуугүй хэлэхэд бол цалинг аваачаад бүр таазанд нь тултал нь аваачаад тавьчихсан юм биш шүү дээ. Одоо ч гэсэн шийдэгдээгүй байгаа. Төсвийн тодотгол хийх байх гэж би бодож байна. Хийх үү гэдгийг 1 дүгээрт тодруулж асууя.

2 дугаарт дөнгөж улсын дундаж цалин руу дөхүүлсэн. Гэхдээ ямар ч байсан энд байж байгаа бүхий л намууд Засгийн газрын мөрийн хөтөлбөрт бол боловсрол, эрүүл мэндийнхээ хөгжлийг дэмжинэ. Хүн төвтэй парламент байна. Хүн бол хамгийн том мега төсөл гэдэг энд чинь зохисон бодлого байхгүй юу. Тэгэхээр та бүгд энийг хариулахдаа, энд тэнд тэр сайд нар хүртэл ярихдаа үүнээс л юм боллоо. Тэгээд бүх юм зогслоо энэ тэр гэдэг ийм яриа чинь бол ний нуугүй хэлэхэд бол таалагдахгүй байна. Эсвэл Засгийн газрын тэргүүн нь энийг зориг гаргаад хийсэн нь буруу гэж хэлэх гээд байгаа юм уу. Тийм учраас яг ний нуугүй хэлэхэд бол боловсрол, эрүүл мэндийн салбарын цалин хөлсний асуудал бол бараг 3, 4 жилийн өмнө хэлэлцээр, гэрээгээрээ тохирчихсон байсан зүйл юм. Улсын дундаж цалинд хүргэнэ гээд. Энийг бол тоохгүй бүр 0 гэж оруулж ирж байгаад, тэгээд яг ний нуугүй хэлэхэд үл итгэлцэл бий болгоод, тэмцэл цуглаан болоод ингээд л явсан. Тийм учраас цааш цаашдаа бас ер нь ирэх 3 жилд цалин хөлсийг ингэе гэдэг энэ зүйлийг бол ялангуяа манай Засгийн газар 3 талт хэлэлцээр энийгээ тохироод ингэж тогтвортой энэ төсөвтэй бас нэг дор ачаалал өгөхгүйгээр зохицуулаад, тэрнийхээ хэлсэн аманд ороод явахгүй бол Засгийн газар болгон гарч ирээд өөр өөр юм яриад байх юм бол энэ нөгөө талын ажилтан, ажил олгогч нар чинь итгэхгүй гээд нэг ийм зөрчил болоод байгаа. Тэгэхээр энэ тал дээрээ анхааръя гэж хэлмээр байна.

Би түрүүнээс хойш асуугаад байгаа 1 зүйл нь яах вэ, төсвийн энэ зүйл дээр ерөөсөө төсвийг л эдийн засгаас бүгдийг нь шахаж гаргая гээд байдаг. Нөгөө талдаа уг нь зөв хийвэл энэ олон ЖДҮ-лэл, энэ ажлын байр хэзээ ч хувийн хэвшил хийж чадахгүй байгаа энэ зүйлүүдийг чинь төсвөөр хийхээс өөр аргагүй шүү дээ. Үүний чинь л үр өгөөж нь хэдэн тоо л хэлмээр байгаа юм. Энэ төсвийг ингэж шийдсэнээр эчнээн ажлын байр бий болно. Төчнөөн ЖДҮ-лэл бий болно. Төчнөөн дэд бүтэц сайжирна гэдэг энэ эерэг үзүүлэлтүүдээ бас би давхар тавиад, ингэж тавихгүй бол зүгээр нэг хэдэн тоо мөргөлдүүлэх гэж байгаа юм шиг л юм тавиад байх юм. Нөгөө талдаа бол яг ний нуугүй хэлэхэд энэ эдийн засаг чинь далд мөнгө бол асар их байгаа шүү дээ. Алтаа ч бид нар ухсан алтаа ч авч чадахгүй, гадаад дотоод хөрөнгө оруулагч нараасаа бодит үр өгөөжөө ч гэсэн бас авч чадахгүй. Тэгээд л хэлэлцээр хийх энгийн түвшинд л явж байгаа. Тэгээд энийгээ бас зарим талаар та бүгд маань энэ төсөв дагасан, хүрээ дагасан энэ тоо мэдээлэл юмнууд дээрээ тодорхой хэдэн юмнуудыг гаргаж тавьдаг бол уг нь олон нийтэд маш ойлгомжтой байхаар байна. Тэгээд явж явж энэ төсвийн чинь гол юм л ерөөсөө ард иргэдийн амьдрал яаж сайжрах бол гэдэг .../минут дуусав/

Н.Наранбаатар: 5 номер хариулъя.

С.Даваасүрэн: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Эмч, багш нарын цалинг нэмсэн асуудлыг бол ерөөсөө ямарваа нэгэн байдлаар сөрөг хандлагаар огт хэлээгүй. Энэ бол бас нэмэх ёстой. Гэхдээ яг ингэж нэмэгдсэнээр төсвийн зарлагад, ялангуяа энэ он болон ирэх оны төсөвт ирж байгаа ачааллын тухай асуудлыг л ярьсан. Тэгэхээр энэ бол төсвийн зарлага тодорхой хэмжээгээр тэлэхэд бол нөлөөлж байгаа 1 гол хүчин зүйл гэдэг байдлаар ярьсан.

Таны асуусан төсвийн задаргаа, тэр дундаа бүтээн байгуулалт, ажлын байр бий болгох, үр өгөөжийн тухай асуудлыг бол төсөв батлах үед намар энэ дээр илүү тодорхой болж гарч ирнэ. Өнөөдөр бол бид төсвийн хүрээнийхээ тухай асуудлыг л ярьж байгаа.

Н.Наранбаатар: Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдааны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн хэн танилцуулах вэ. Эрдэнэбат гишүүн танилцуулна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

10.39 цаг.

3 дахь асуудал.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүн хэвээрээ.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Заяабал танилцуулна.

Б.Заяабал: Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 5 сарын 1-ний өдөр Монгол Улсын Их Хуралд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн мэдүүлсэн.

Уг төслийн үзэл баримтлал болон төслөөр зохицуулах харилцаа нь Монгол Улсын Их Хурлаас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зохицуулалтыг бүхэлд нь хүчингүй болгох асуудлыг хөндсөн.

Гэвч хуулийн төсөлд одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1 дэх заалтыг яг тухайн бичилт бүхий үг, өгүүлбэр найруулгаар өөрчлөн найруулахаар тусгаж, өргөн мэдүүлсэн.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.9 дэх хэсэгт “өөрчлөлт оруулж байгаа зүйл, хэсэг, заалтын зарим нэр томьёо, үг хэллэгийг өөрчилсөн буюу хассанаар түүний утга агуулга нэг мөр ойлгогдохгүйгээр байвал түүнийг өөрчлөн найруулна” гэж заасан байдаг. Гэтэл хүчин төгөлдөр үйлчилж байгаа тухайн хуулийн тухайн заалтыг яг тухайн бичилт бүхий үг, өгүүлбэр, найруулгаар өөрчлөн

найруулна гэдэг нь Хууль тогтоомжийн тухай хуулийн дээрх заалттай зөрчилдөхөөр байсан.

Нэгдсэн хуралдаанаас хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хуулийн зөв техниктэй болгож, хэлэлцэх шаардлага үүссэн. Иймээс Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар Засгийн газраас өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцааж, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тухай хуулийн төслийн 3 дахь хэлэлцүүлгийг явуулах үед Монгол Улсын Их Хурлаас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчингүй болгох хуулийн төслийг Байнгын хорооноос санаачлан боловсруулж хэлэлцүүлэх гэсэн зарчмын зөрүүтэй санал гаргаж, Байнгын хороо нэгдсэн хуралдаанаар тус тус хэлэлцүүлсэн.

Уг саналыг нэгдсэн хуралдаанаар дэмжсэнээр Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.25 дахь хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.12 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас хуулийн төсөл буцаах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталсан.

Уг саналтай уялдуулан Монгол Улсын Их Хурлаас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг санаачлан боловсрууллаа.

Хуулийн төсөл 1 зүйлтэй. Энэ зүйлээр Монгол Улсын Их Хурлаас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох зохицуулалтыг тусгасан болно.

Дэмжиж өгөхийг хүсье ээ гишүүд ээ. Баярлалаа.

Н.Наранбаатар: Заяабал даргад баярлалаа. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг та бүхэнд тараасан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэх бөгөөд Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл 1 зүйлтэй. Төслийг зүйл бүрээр хэлэлцэж эхэлье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Батжаргал гишүүнээр тасаллаа. Ганбаатар гишүүн асуулт асууна.

Ж.Ганбаатар: Баярлалаа. Энэ чинь саяхан би тэр 8 дугаар микрофоноос асууж байгаа шүү. Сангийн яам наашаа хараарай. Занданшатар даргын сайд байх үед нь та нар чинь зогсоод бүр бүх тооцооллоо яриад, дэмжсэн шүү дээ. Сангийн сайд, Занданшатар Ерөнхий сайд та бараг байсан байх. Тэгээд яагаад өнөөдөр ингээд хүчингүй болгож байгаа юм. Би байсан уу, үгүй юү гээд асууж байх шиг байна. Тэгээд энэ чинь арай дэндэж байгаа юм биш үү. Тэгээд энэ үед чинь олон хүмүүс анхааруулаад байсан шүү дээ. Тэгээд энэ байж болохгүй асуудал.

Хоёрдугаарх асуудлыг нь ярья. НӨАТ-тай холбоотой 2 дахь асуудал шүү НӨАТ-тай холбоотой ингээд Засгийн газраас сая НӨАТ-ын татвар төлөх босгыг 50 саяыг 400 сая болгосон. Тэгээд тухайн үед Сангийн сайд их олон жил Сангийн сайд хийсэн хүн энийг жадлан эсэргүүцээд, татварын тогтолцоогоо эвдэж байна энэ тэр гээд юм яриад байгаа юм. Би 5 номерын микрофоноос асууя. Энэ байна шүү дээ өөр аргаар шийдэх бүрэн бололцоотой шүү дээ. Татварын аргаар. Миний суурь мэргэжил нягтлан бодогч л доо. Тэгэхээр энийг байна шүү дээ, дансны бичилтээр, эсвэл татвараа бүгдийг нь төлүүлчхээд буцааж олгох маягаар тэр 8 номер толгой дохиж байна. Баярлалаа. Ингэж болно шүү дээ. Тэгэхгүй тэр Сангийн сайдын хэлж байгаагаар тогтолцоогоо бүгдийг нь эвдэж биш, үгүй ээ энэ чинь зөндөө арга байгаа шүү дээ.

Та нар мэдэхийн дээдээр мэдэж байгаа. Бүгдээрээ НӨАТ-н падаанаа бичиж өгдөг л байя л даа. Тэгээд хөнгөлөлт чөлөөлөлтийг нь та нар зохицуулалтаараа хий. Тэгэнгүүтээ тэгээд энэ жижиг дунд аж ахуйн нэгжүүд чинь бүр би одоо янз янзын юм ярихгүй байя гэж бодъё. Бүр маш хэцүүдэж байгаа шүү дээ. Тэгэхээр энийг дэмжсэн Засгийн газрын бодлогыг би бол дэмжиж байгаа. Учрал Ерөнхий сайд өөрөө энийг бол ил гаргаж ярьсан. Маш зөв. Тэгээд зарим нэг хүмүүс, Сангийн сайд их олон жил хийсэн хүн ингээд бодлого эвдэж байна гээд. Тэр хүн тийм аргачлалаа мэддэггүй юм уу. Би энэ аргачлал, энэ зүйлийг, энэ санааг би анх удаа хэлээгүй. Тэр олон НӨАТ-ын юунууд Их Хурлаар хэлэлцэгдэж байсан. Тухайн үед сүү, мах юу юу ч билээ өндөг чөлөөлөгддөг. Үгүй ээ, та нар нэг мөсөн том тогтолцоогоор нь наадхаа өөрчлөөч ээ гэж. Бүгдээрээ татвараа төлчхөөд наад том аж ахуйн нэгжүүд чинь бол бүрэн бололцоотой. Буцаагаад авчих. Тайлангаа гаргаад, эсвэл .../минут дуусав/

Н.Наранбаатар: Хэн хариулах вэ. 5 номероос түрүүн асуусан. 8 номер хариулъя.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж гишүүний асуултад хариулъя. НӨАТ-ын тухай хуулийг бол өнгөрсөн жил батлуулсан. Сая энэ жилийн хувьд тэгэхдээ бид төсвийн хувьд 1 зүйл байна гэдгийг Эдийн засаг, хөгжлийн яамтайгаа ч яриад, бүх талаас нь харж байгаад давхцуулж байгаад ярьж байгаа. Тэр нь юу вэ гэхлээр инфляцын маш хүнд, өндөр үе ирж байна. Тэгээд энэ нь 2-3 жил бол дор хаяж үргэлжлэхээр байна гэдэг зүйл бид ярьсан. Тэгээд яах вэ, бүх нөгөө тооцоо судалгаанууд бол энэ дээр гарч ирж байгаа. Тэгэхээр инфляцад хамгийн хүндээр зохидог магадлалтай яг тэр хэсэг маань өөрөө НӨАТ-тай бараа бүтээгдэхүүн харьцангуй бага хэрэглэж байна.

Нөгөө талдаа яг энэ сегмент дээр орлогын дийлэнх хэсэг нь илүү татварын бодлогоос гэхээс илүү орлогын дийлэнх хэсэг нь өөрөө тэтгэвэр, халамж байгаад байгаа юм. Тэгэхээр илүү төсвийн бодлогоор энэ хэсэг дээрээ бид нар нөлөөлөх нь зүйтэй байна гэж харсан юм. Тэгэхээр ирэх жил дээр бид нар илүү энэ чиглэлдээ анхаарч явах нь зөв байна. Нөгөө талдаа илүү аж ахуйн нэгж талуудаа харахаар бүх салбараар нь бас салгаад тоонуудаа үзэхээр нөгөө НӨАТУС-ын системээс үзэхээр ялангуяа жижгэвтэр аж ахуйн нэгжүүд бол 2,5 тэрбумаас доош борлуулалттай аж ахуйн нэгжүүдийн хувьд бол зарлага нь өөрөө орлогын өсөлтөөсөө илүү өндрөөр өсчихсөн. Ашгийн хэмжээ бол нэлээд буурчихсан ийм тооцоонууд гарч ирчхээд байгаа юм. Тэгэхээр энэ хэсэг дээр бид илүү их ажлын байрыг хадгалах чиглэлээр, тэр дундаа хувь хүн ААНӨАТ дээр илүү энэ хэсэг дээрээ бид нар чиглэж ажиллах нь зүйтэй байна гэдэг ийм агуулгаар тооцоод явсан.

Тийм учраас нөгөө талдаа ирэх жилийн төсөв дээр бид нар зарлагыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх шаардлагатай болсон. Энэ агуулгаар НӨАТ-ын энэ хууль маань нөлөөлөл нь 1,6-1,8 их наядын нөлөөлөлтэй байгаа. Тэгээд энэ орлогыг бид нар алдахгүй байж байгаад, нөгөө талдаа халамжийг мөн тэтгэврийг ирэх жил нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байна гэж үзсэн байгаа.

Ер нь бол Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж олгох тухай хуулиар бол өмнөх оны инфляцтай нь уялдуулж тэтгэврийг нэмдэг хуультай. Цалин бол одоогоор байхгүй байгаад байгаа. Ямар нэгэн байдлаар хуулийг бол ингэж жил болгон нэмнэ гэдэг зүйл. Тэгэхдээ Монгол Улсын Ерөнхий сайд бол ирэх жилийн төсөвтэй хамт цалинг зохицуулж байгаа 33 хуулиа оруулж ирнэ гэдэг ийм байдлаар явсан.

Түрүүн нөгөө НӨАТ-ын системийн хувьд бүртгэлийн хэсэг дээр бол манай систем цахимжчихсан байж байгаа. Шийдэл нь бол байж байгаа.

Н.Наранбаатар: 5 номер хариулья.

С.Даваасүрэн: Тэгэхээр Эдийн засаг, хөгжлийн яамны хувьд бол яг энэ НӨАТ-ын буцаан олголтын энэ бодлогыг 2 хувиас 5 хувь байхыг өөрчлөх дээр ер нь бодлого дээрээ бид нар орлогоо дэмжих, орлогыг нэмэгдүүлэхийг дэмжих үү, эсвэл хэрэглээгээ дэмжих үү гэдэг бодлогын 2 сонголтоос л 1-ийг нь гаргаж байгаа гэж харж байгаа. Юу вэ гэхээр хэрэглээний хувьд бол НӨАТ-ын буцаан олголтын хувь хэмжээг нэмэгдүүлэх нь илүү хэрэглээг дэмжиж байгаа. Хэрэглээг дэмжих замаар эдийн засгаа идэвхжүүлэх. Тэгээд буцаан олголтын хувь хэмжээг нь хараад үзэхэд ялангуяа бага орлоготой иргэдийн хувьд НӨАТ-аас буцаан олголт авч байгаа хувь хэмжээ бол харьцангуй бага байгаа юм.

Харин татварынхаа бааз суурь өөрөөр хэлбэл сая гишүүн хэллээ. 50 саяас 400 сая болгох замаар татвар суутгах тэр хэмжээг өргөтгөснөөр эргээд иргэддээ очих орлогыг нь нэмэгдүүлэх замаар дэмжих нь илүү их үр өгөөжтэй. Дээр нь нөгөө төсөв дээр яг үгүйлэгдээд байгаа 1,6-1,8 их наядын орон зайгаа хэрхэн яаж бүрдүүлэх вэ гэдэг дараагийн сонголтыг сая Сангийн яам бол тайлбарлалаа. Энэ 2 сонголтоос л НӨАТ-ын буцаан олголтын тухай энэ хуулийн өөрчлөлт нь яригдаж байгаа.

Н.Наранбаатар: Ганбаатар гишүүн тодруулья.

Ж.Ганбаатар: Санжаа гүйцээгээд хариулаарай. 2 асуудал байгаа шүү дээ. Тэр 5 номерт хэлэхэд 2 өөр асуудал шүү. Санжаа энэ гүйцэтгэх засаглалын хүмүүс Их Хурлын гишүүдтэй адилхан ямар мэтгэлцээн хийдэг биш. Энэ сошиалаар ажил хийдгээ болих хэрэгтэй шүү дээ. Тэгэхгүй бол та нар тухайн үеийн нийгмийн сэтгэхүйд л тааруулаад Занданшатар даргад буруу мэдээлэл өгөөд болно, болно гээд. Тэгээд энэ өнөөдрийн хүчингүй болж байгаа асуудлыг тоон мэдээллээ дутуу өгөөд л зарлуулсан гэсэн үг. Хариултаас чинь сонсоход. Тэгээд өнөөдөр хүчингүй болгуулна гээд. Энэ юу яах хэрэгтэй л дээ. Би зүгээр Учрал Ерөнхий сайдад хэлж байгаа юм. Энэ гүйцэтгэх засаглалын хүмүүс сошиалаар юмаа явуулаад, тэрийгээ ялангуяа сайд нар бол болих хэрэгтэй. Хамгийн чимээгүй, хамгийн сайн ажлаа хийсэн сайд бол хамгийн сайн сайд байх ёстой. Их Хурлын гишүүд бол үзэл бодлоо илэрхийлэх гэж л энд сууж байгаа. Мэтгэлцэх гэж. Одоо энэ төрд ажиллаж байгаа хүмүүс бүр доошийгоо дүүрэг, хороо бүгдээрээ сошиалаар ажил хийдэг болсон. Энийг болих хэрэгтэй байхгүй юу. Тэгээд маш олон хүлээлт үүсгэчихсэн. Энэ асуудал чинь маш их хүлээлт үүсгэчихсэн. Тэгээд өнөөдөр хүчингүй болж байгаа

юм. Тэгээд наад 400 саяын асуудал чинь бол Засгийн газраас сая шинэ байгуулагдсан Засгийн газраас өргөн баригдсан асуудал. Энийг бол татварынхаа системийг эвдэхгүйгээр засах бүрэн боломжтой шүү. Санжаа энийгээ тэр хуучин Жавхлан сайддаа ойлгуул. Тэгээд энэ чинь бол жинхэнэ зүгээр нийгэмд маш том хүлээлт үүсгэж байгаа юм. Энийг бол хийх ёстой. Жижиг, дунд аж ахуй, иргэдээ дэмжих ёстой. Систем эвдэхгүйгээр хийх бүрэн боломжтой.

Н.Наранбаатар: 8 номер Санжаадорж дарга хариулья.

М.Санжаадорж: Санжаадорж Сангийн яам. Гишүүний асуултад хариулья. НӨАТ-ын босгыг нэмэгдүүлэх асуудал өөрөө бас нэлээд яригдсан сэдэв болчхоод байгаа. Нэг талаараа таны хэлж байгаатай би бас мэдээж хэрэг санал 1 байна. Манайх систем бэлэн. Аль болох нөгөө хасагдуулалтаа бүрэн хийгээд явах нь зүйтэй байдаг. Тэр онол нь бол тийм. Гэхдээ одоо бид нар яаж байна гэхээр НӨАТ-ын хууль анх танилцуулагдсан тэр оноос хойшоо гэхэд жишээ нь сүү, гурилан дээр жишээ нь НӨАТ-гүй энэ хэсэг бол ингээд яваад байдаг. Тэгэхээр бид нар бол энийг яаж бүр анх энэ хууль батлагдахдаа л ингээд явчихсан байгаад байдаг. Нөгөө талдаа НӨАТ бол өөрөө бас жижиг аж ахуйн нэгжийн хувьд нэлээд бас ачаалал болоод байна гэдэг ийм судалгаа бас байдаг юм байна лээ. Тэгээд миний ойлгосноор бол намын мөрийн хөтөлбөрүүд дээр аль алин дээр нь бас энэ босго оноог өсгөх асуудал, босгыг өсгөх асуудал байсан учраас орж ирсэн гэж ойлгож байгаа. Татварын бодлогын газрын дарга хариулах байх.

Н.Наранбаатар: 2 л тодруулна. Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Тэгэхээр Засгийн газраас энэ татварын бодлогын чиглэл дээр тодорхой бодлогын өөрчлөлт хийж байгаа юм байна гэж би бол ингэж хараад байгаа юм. Бага, дунд орлоготой хэсгээ үйл ажиллагаа орлого талаар нь дэмжих үү эсвэл бага орлоготой, дунд орлоготой хэсгээ хэрэглээ талаар нь дэмжих үү гэдэг асуудал үүсчихсэн. Одоо бидний яриад байгаа энэ Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн асуудал бол үндсэндээ сард 75 мянган төгрөгийн буцаалтын тухай ойлголт байсан.

ХХОАТ-ын тухай хуулиар 792,000 төгрөгийг татвараас чөлөөлөлт хийчихээр зэрэг 79,200 төгрөгийн буцаалт үндсэндээ очиж байгаагаар ойлгогдож байгаа. Тэгэхээр энэ зөрүүгээрээ бол би 4 мянга гаруй төгрөгийн нэмэгдэл байдлаар иргэд дээр үлдэж байгаа юм байна. Тэгэхээр Засгийн газар маань аль болохоор энэ эдийн засгаа тэлэх, идэвхжүүлэх, баялаг бүтээгчдээ дэмжих, үйл ажиллагаа, орлого талаа дэмжих энэ үүднээсээ асуудалдаа хандаж, бодлогын нэлээн өөрчлөлт хийж байгаа юм байна гэж энэ талаас нь би Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн асуудлыг хараад байгаа юм. Тэгээд төсвийн хүрээ төсөөлөл талдаа бид нэгэнт энэ хуулийг дагуулж өргөн барьсан учраас тооцооллоо энэ хэлбэрээр нь тусгаад оруулсан гэж ингэж ойлгож байгаа.

Төсвийн хүрээг нь явуулчихсан бол дагасан хуулийнх нь зохицуулалтыг хийж өгөхгүй бол тооцооллын алдаа одоо бидний маргалдаад байгаа тодотгол энэ тэрийн чинь юм дахиад л яригдах болно. Тэгээд энд нэг зүйлийг ойлгомоор байгаа юм. Энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг бид бүгдээрээ сууж байгаад эргэж харахгүй бол болохоо байчихсан юм билээ. 2010 онд Монгол Улсын эдийн засаг ер нь ямархуу хэмжээний багтаамжтай юм байсан. Төсвийн орлогын бүрдэл гэж ер нь юу төсөв гэж ер нь ямархуу хэмжээний юм байсан бэ. Тэр цаг үед төсвийн сахилга, хариуцлагыг чангатгах талаар ер нь ямар бодлого барих вэ гээд ингээд

явсан. Гэхдээ төсвийн тодотголоо ийм ийм нөхцөл байдал үүссэн үед хийх ёстой гэдэг ийм тусгай шаардлагыг нь тавиад өгчихсөн. Хэрвээ тийм нөхцөл байдал үүсчихсэн бол 1 өдөр ч болтугай хойшилж болохгүйгээр асуудлаа зохицуулах ёстой. Гэтэл аваачаад хэдүүлээ Төсвийн тогтвортой байдлын тухай хуульдаа үүнээсээ зөрсөн юм шиг түгжээнүүд хийсэн. Тэр нь төсвийн хүрээгээ баталчхаад, 3 сарын дотор тодотгол хийж болохгүй. Өөрчилж болохгүй гэдэг үндсэндээ нэлээн тийм мөлхүүлэх, элгээр нь хэвтүүлэх юмаа хийж байж хийдэг ийм горимын заалт хийчхээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ талаасаа харах юм бол энэ.../минут дуусав/

Н.Наранбаатар: Тодруулъя. Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Энэ талаасаа харах юм бол энэ Төсвийн тогтвортой байдлын хуульд байгаа янз бүрийн түгжээс заалтуудыг агуулга талаас нь харж зөв болгохгүй бол боломгүй юмнууд байгаад байгаа юм байна лээ. Үүнийгээ бид хаа хаанаа хүлээн зөвшөөрөх ёстой гэж. Нэмэгдсэн өртгийн албан татварын энэ ярьж байгаа асуудал дээр орж ирсэн хуулийг нь хууль санаачлагчид нь буцаачхаад, тэгээд тэр хуулийн үзэл баримтлал дээр тулгуурлаад хууль хүчингүй болгох хуулийг эндээс хийчихнэ гэж ер нь байж болох уу. Юу гэж ойлгоод байна. Энэ л их сонин асуудал болчихоод байгаа юм. Би хууль зүйн манай мэргэжлийн баг, Тамгын газар, хуульчдын баг нь зөв гээд байгаа гээд байгаа юм. Тэгэхээр болдог юм уу, үгүй юм уу. Энэ чинь хүний үзэл баримтлалаар орж ирсэн хуулийг буцаачхаад, тэгээд тэр үзэл баримтлал дээр тулгуурлаад энд хуулийн төсөл боловсруулна гэж ер нь байж болох юм уу, болохгүй юм уу энэ чинь.

Н.Наранбаатар: Хэн хариулах вэ. Батжаргал гишүүний асуултад хариулъя. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1 дэх заалт нь Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсөлд өөрчлөн найруулахаар хөндөгдөн 15 дугаар зүйлийн 15.2.1 дэх заалттай үг, үсэг, найруулгын хувьд давхцсан бөгөөд өргөн мэдүүлсэн төслөөр зохицуулсан харилцаа үзэл баримтлал нь Монгол Улсын Их Хурлаас 2025 оны 11 сарын 14-ний өдөр батлагдсан НӨАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зохицуулалтыг бүхэлд нь хүчингүй болгохоор тусгагдаж өргөн мэдүүлсэн.

Мөн нэгдсэн хуралдаанаас хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд зөв техниктэй болгож хэлэлцүүлэх шаардлага үүссэнтэй холбогдуулан Засгийн газраас өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах, үүнтэй уялдуулан Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлаас 2025 оны 11 сарын 14-ний өдөр баталсан НӨАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын 20 хувийг шаталсан хэлбэрээр нэмэгдүүлж, 100 хүртэл хувь хүргэн 2026 оны 10 сарын 1-ний өдрөөс хэрэгжих хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Байнгын хороо санаачлан боловсруулан танилцуулсан.

Тэгэхээр Байнгын хорооны зөвлөхүүд, Тамгын газрын мэргэжилтнүүдээс бид нар бас тодруулж ийм л төслийг оруулж байгаа юм. Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Би бол дэмжиж байгаа. Зөрөөд байгаа юм байхгүй. Хүний оруулаад ирчихсэн хуулийг буцаачихсан байхгүй юу. Наадах чинь хууль зүйн техник талаасаа давхцал үүссэн болохгүй байна гээд буцаачихсан. Үгүй ээ, тэгээд одоо энд

ямар үзэл баримтлал дээр тулгуурлаж хууль боловсруулаад байгаа юм бэ. Тэр үзэл баримтлал чинь аль цагийг нь буцчихсан байхгүй юу. Тэгэхээр би энэ хуулийг баталлаа гэхэд Их Хурлын хийгээд Дэгийн хуулийн зөрчлүүд үүсэхгүй юм уу гэдэг энэ талаас нь хараад байгаа юм. Та нарын наад яриад байгаа юмыг ерөөсөө учрыг нь олохгүй болчихоод байгаа байхгүй юу. Хүний оруулж ирсэн хуулийн үзэл баримтлал тэр юмнуудыг ойлгож байгаа. Тэгсэн хэр нь хууль зүйн техник талаасаа энэ болохгүй юм байна гэж үзээд буцаах шийдвэрийг Их Хурал гаргачихсан. Тогтоол гаргачихсан шүү дээ. Тэгэхээр одоо ямар юмаа үндэслэж хуулийн төсөл боловсруулаад байгааг би тэрийг чинь учрыг нь олохгүй байгаа байхгүй юу.

Н.Наранбаатар: Тэгээд энэ дээр ингээд байгаа юм. Саяын нөгөө Байнгын хороо яагаад өргөн барьж байгаа юм гэдэг дээр 42.5 дээр ... тэгэхээр нөгөө тэр өмнөх хуулиа хүчингүй болгох зайлшгүй шаардлагатай болчихож байгаа байхгүй юу. Тэгэхгүй бол өмнөх хуулиараа явчихна. Энэ дээр ингээд байгаа юм. Тэгэхээр нөгөө 11 сарын 14-ний хууль нь үлдчихээд байгаа биз дээ.

Би протоколд тэмдэглүүлж үлдээх үүднээс хуулийн заалтыг нь уншиж өгье. Дэгийн тухай хуулийн 42.5-д “анхдагч болон хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хэлэлцүүлгээр санал хурааж шийдвэрлэсэн зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулан Байнгын хороо төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ хууль тогтоомжийн хоорондын уялдааг хангах зорилгоор холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулан хамтад нь хэлэлцүүлж болно” гээд ийм заалт байгаад байгаа байхгүй юу. Тэгээд 42.8-д энэ хуулийн 42.5-д заасны дагуу боловсруулсан төслийг энэ хуулийн 39, 40, 41, 42, 43, 44 дүгээр зүйлд заасны дагуу хэлэлцэн батална гээд. Ганхуяг гишүүн асуулт асууя.

Х.Ганхуяг: Яах вэ, энэ 3 асуудал байна. Энэ төсвийн тодотголтой холбоотой асуудал дээр бол дэмжиж байгаа юм. Тэгээд яах вэ манай Тогтвортой байдлын зөвлөлийнхөн сайн төлөвлөсөнгүй, сайн урьдчилж харж чадахгүй байна гээд ийм жоохон прагматик баймаар байна. Энэ дайн, Ормузын хоолой, Украйны нөхцөл байдлыг ер нь яаж ч урьдчилж харах боломжгүй байхгүй юу. Энэ чинь бүр өдөр болгон өөрчлөгдөж, өдөр болгон түлшний, эрчим хүчний үнэ өөрчлөгдөж байхад урьдчилж харна гэж бас яг юу ч яриад байгаа юм. Тэгээд энэ Төсвийн тогтвортой байдлын хуулиа бид нар жоохон өөрчилмөөр байна, жоохон засмаар байна, жоохон прагматик болгомоор байна. 1 дүгээр асуудал.

2 дугаар асуудал яг сая Батжаргал даргын хэлээд байгааг хэлэх гээд байгаа юм. Их Хурал санал хураагаад буцаачихсан хуулийг Байнгын хорооноос санаачилж оруулна гэж яг юу яриад байгаа юм бэ. Ингэж болохгүй шүү дээ. 1 дүгээр асуудал.

2 дугаар асуудал юу вэ гэхээр яг дараад нь Засгийн газраас юу гэж ярих вэ гэхээр Их Хурал тэр хуулийг чинь буцаачихсан, хүчингүй болгочихсон гэж ярих байхгүй юу. Сая цалин тэтгэврийг нэмэх асуудал дээр сайд нар орж ирээд юу гэж хэлсэн гэхээр Их Хурал нэмчихсэн шүү дээ. Бид нар мэдээгүй байхад нэмчихсэн гэж ярьсан шүү дээ. Тэгж Засгийн газрын урдуур орж ийм хууль санаачилж болохгүй ээ 2 дарга аа. 2 дугаар асуудал.

3 дугаар асуудал энэ яг НӨАТ-ын асуудал руу би бол дэмжихгүй байр суурьтай байгаа. Та нар чинь нэгийг нь хараад л нэг юм ярихаар тийм гэгчхээд, нөгөөдөх нь шал эсрэг байр суурьтай асуудал илэрхийлж байхад, байр суурь илэрхийлж байхад тийм ээ л гээд сууж байх юм. Үгүй ээ, тэгээд НӨАТ-ын босго нэмэгдүүлэхэд чинь далд эдийн засаг чинь томордог юм байгаа биз дээ. Жижиг, дунд аж ахуйг дэмжиж

байгаа юм гээд байгаа юм. Үгүй ээ, тэр тэр НӨАТ-ын хууль гэдэг чинь бүртгэлийн хамгийн эцсийн хэрэглэгчээс л авдаг л татвар шүү дээ. Тэгээд 400 саяын босго нэмэгдүүлэхээр чинь тэр жижиг, дунд аж ахуйн нэгж чинь харин ч бүр юм зарж чадахаа болино. Гадаад импортоос орж ирж байгаа бүтээгдэхүүнд өрсөлдөж чадахаа болино шүү дээ. Тэр чинь өртөг нь улам л нэмэгдэнэ. Харин ч бүгдээрээ НӨАТ төлөгч болж байж тэр малчдын зарж байгаа, гар дээрээс зарж байгаа юу байдаг юм тэр хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа тэр жижиг дунд аж ахуй харин энийг дэмжих ёстой байхгүй юу. Дэмжиж байгаа хууль шүү дээ тэр чинь. Тэгэнгүүт одоо НӨАТ-ын босго нэмэгдүүлэнгүүт жижиг дундаа дэмжиж байгаа юм гэж одоо яриад сууж байх юм Санжаа. Үгүй ээ, та нар чинь яахаараа ингээд 180 градус эргээд байдаг юм. 6 сарын өмнө энэ чинь жижиг, дундаа дэмжиж байгаа юм. Эцсийн хэрэглэгчид нь бид нар НӨАТ-ын буцаалтыг нэмж өгснөөрөө харин ч бүртгэл сайжирна л гэж ярьсан. Тэгсэн чинь одоо НӨАТ-ын буцаалтыг тансаг хэрэглээнийх юм гэж юу яриад байгаа юм бэ. Тэгээд 2 хамтарсан Байнгын хорооны хурал болж байгаа сайд нар нь байхгүй. Тэгээд орж ирсэн хүмүүс нь 1 хүн юм хэлэхээр л 180 градус эргээд, нөгөө хүн юм хэлэхээр 180 градус дэмжиж байгаа юм гээд байх юм.

Н.Наранбаатар: Хэн хариулах вэ. 9 номер.

Ч.Чимидсүрэн: Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр өмнө хэлэлцүүлгийн шатад энэ НӨАТ-ын системийг цогц системээр нь, тогтолцоогоор нь авч үзэх ёстой гээд энэ талаар нэлээдгүй судалгаа, шинжилгээ хийсэн. Мөн татвар төлөгчдийн саналыг авч нэгтгэж, боловсруулсан. Яах вэ, тэр санал дээр бол бүх нийтээрээ татвар төлөгч байя, тэгээд бүх чөлөөлөлтүүдээ хүчингүй болгоё гэсэн энэ үндэслэл дээр хийгдээд энэ заалт бас 1 заалт нь буюу төсөв дагаж орсон байгаа. Тэгэхдээ энийг дагаад нэлээн хэдэн зохицуулалтууд хийж байж энэ НӨАТ-ын систем нь өөрөө ажиллахаар ийм тогтолцоо байсан. Тэгэхээр энэ дараагийн өргөн барьсан хуулиуд дээр тэр төслүүд маань тохиргоонууд нь хийгдэх тэр төслүүд маань бол татагдчихсан учраас энэ удаа Засаг дээр ярьж байгаад ер нь олон тийм өөрчлөлтүүд орохгүйгээр төсөвтэй холбоотой цөөхөн өөрчлөлтүүдийг нь нэмэлт, өөрчлөлт хийгээд явчихъя. Татварын цогц шинэчлэлийг бол дараа нь хийе гэдэг утгаараа ярьсан. Энэ дээр бас НӨАТ-ын босгыг харин оруулъя. Энэ нь жижиг, дунд бизнес эрхлэгчдээ энэ удаа тодорхой хэмжээний ачааллаас багасгая гэдэг утгаар энэ асуудлыг оруулсан байгаа юм. Одоо хүчингүй болж байгаатай холбоотой дээр бол та бүхэн мэдэж байгаа энэ НӨАТ-ын татвар бол хэрэглээний татвар. Буцаан олголт очиж байгаа энэ зүйл нь бол өндөр хэрэглээтэй цөөн хэсэгтээ буцаалтын дийлэнх хэсэг нь очоод байгаа юм. Одоо бид нар 10 сарын 1-ээс 5 хувиар НӨАТ-ын буцаалтыг олгох юм бол энэ урамшууллын 75-80 хувь нь өндөр хэрэглээтэй 25 хувь дээрээ очихоор байгаа юм. Нэг талаар. Нөгөө талаар энэ НӨАТ-ын босго чинь өөрөө 10 саяар бол сайн дурын НӨАТ төлөгч болох эрх нь нээлттэй байгаа шүү дээ. Энэ бол энэ удаа хөндөгдөөгүй явж байгаа гэсэн үг. Тэгэхээр НӨАТ төлөгчөөрөө, суутган төлөгчөөрөө ингээд үйл ажиллагаагаа цааш үргэлжлүүлье гэж байгаа байгууллагууд дээр бол энэ 10 сая хэвээрээ байгаа гэдгийг бас нэмж хэлье.

Тэгээд бидний тооцооллоор бол ингэж байгаа юм. 700 мянган төгрөгөөс бага орлоготой 83500 өрхийн хүнсний зардлынх нь 90 орчим хувийг нь мах, сүү, гурил зэрэг НӨАТ-аас чөлөөлөгддөг бүтээгдэхүүн эзэлж байгаа юм. Тэгэхээр иймд энэ 700 мянган төгрөгөөс бага орлоготой өрхийн сард дунджаар 37 мянган төгрөг л буцаан олгож байхаар, 2,1 сая төгрөгөөс дээш орлоготой өрхөд бол 137 мянган буцаалт олгохоор байгаа байхгүй юу. Тэгэхээр өндөр орлоготой хэсэгтээ 137 болгоод байдаг, 700 мянгаас бага орлоготойдоо 37 мянгаар гээд 3,7 дахин ийм өндөр

буцаалт олохоор байгаад байгаа юм. Тэгэхээр энэ удаа Засгийн газар дээр бол ярьсан зүйл хэрэглээг нь дэмжих үү, эсвэл энэ хөдөлмөр эрхлэлтийг нь дэмжээд орлогыг нь хамгаалах уу гэдэг энэ сонголт дээр л энэ хувилбарыг бол оруулсан байгаа юм.

Н.Наранбаатар: Ганхуяг гишүүн тодруулъя.

Х.Ганхуяг: Гүйцэд хариу авсангүй л дээ. Сая би чинь бол НӨАТ-ын хуультай холбоотой, энэ хүчингүй болгож байгаа хуулийн заалттай холбоотой 1 асуулт, Тогтвортой байдлын зөвлөлөөс 2 дахь асуулт, 3 дахь асуулт бол сая тэр буцаалттай холбоотой асуулт ярьсан байхгүй юу.

Яах вэ НӨАТ-ын буцаалттай холбоотой асуудал дээр чинь бид нар бол ерөөсөө 1 сая төгрөгөөр л тогтоосон шүү дээ. 1 сая төгрөг хүртэл гэж байгаад. Тэгэхээр яахаараа өндөр хэрэглээтэй иргэдийг дэмжээд байгаа гэдэг асуудал яриад байгаа юм бэ. Тэр чинь ямар тэр даяар нь буцаалт хийх гээд байгаа биш. Харин тэр чинь дандаа л хэмжээтэй тавьсан шүү дээ. 500 мянга дээр 100 хувь, 1 сая төгрөг дээр 50 хувь, тэрнээс дээш бол одоо хуучин байгаагаар 20 хувь гээд. Тэгээд мөнгө байхгүй л гээд байх юм. Уг нь бол энэ чинь 2028 оны 1 сарын 1-ээс хэрэгжүүлэхээр хойшлуулчихсан бол энэ төсвийн орон зай чинь 2028 онд бол хангалттай л харагдаж байна шүү дээ. Яг энэ төсвийн хүрээг харвал 38 их наяд болчихсон байна гэдгээр л тооцоолж байгаа юм байна. 6 сарын дараа ингээд хуулиа өөрчилнө гээд орж ирж болохгүй байхгүй юу.

Яах вэ, цөмөөрөө 1 юман дээр жоохон хуулийн өөрчлөлт хийж байвал бид нар ядаж урагшаагаа 1 алхдаг баймаар байна. 6 сарын өмнө 1 алхчаад, 6 сарын дараа хойшоо 2 алхана гэж хуулийн төсөл оруулж ирж болохгүй байхгүй юу. Тэгээд Чимидсүрэн 6 сарын дараа байр суурь чинь бас өөрчлөгддөг байж болохгүй. Татварын бодлогыг та тэнд Сангийн яам дээр ахалж байгаа бол татварын бодлогоо аль болох зөв болгох талаас нь цөмөөрөө өөрчлөлт хийгээд явах ёстой шүү дээ. Тэр дарга нартаа бас хэлдэг байх ёстой шүү дээ. Тэгээд дараа нь сайд нар чинь орж ирээд юу гэдэг вэ гэхээр Их Хурал тооцоолоогүй, төсөвт байхгүй мөнгө нэмчихсэн гэж ярьдаг. Их Хурал бол төсөвт байгаа мөнгөөрөө л бид нар тэтгэвэр, цалингаа нэмсэн. Та нар харин очоод илүү мөнгө нэмчихсэн шүү дээ. Ер нь Засаг бол. Одоо юу гэж ярих вэ гэхээр энэ 2 дарга энэ Байнгын хороо энэ хуулийг хүчингүй болгочихсон юм л гэж дараа нь ярих юм байна лээ шүү дээ. Тэгээд Их хурал санал хураагаад буцаачихсан хуулийг дахиад оруулж байна гэж юу .../минут дуусав/

Н.Наранбаатар: Үгүй ээ, энэ чинь юу байхгүй юу даа. Түрүүн тайлбарласан шүү дээ зөндөө. Энэ төсвийн хүрээний мэдэгдлийг өргөн барихдаа 2 хууль дагуулсан үзэл баримтлалд нь 2 хуулиа ингээд тусгачихсан. Тэгээд тэрнийх нь дагуу чуулганаар дэмжчихсэн. Техникийн засвар оруулж байгаа шүү дээ энэ дээр. Түрүүн тайлбарласан. Биш ээ, Засгийн газраас оруулж ирсэн нь хэлэлцэх эсэх нь дэмжигдчихсэн. Тэгээд засвар оруулаад, Байнгын хорооноос санаачлаад, засвар оруулаад л явж байгаа. Тэгэхгүй бол 1 заалт 2 тусчих гээд байсан байхгүй юу даа. Тэндээс хариу нэмж хариулах уу. 8 номер.

М.Санжаадорж: Санжаадорж Сангийн яам. Гишүүний асуултад хариулъя. Манай нөгөө хийсэн тооцоогоор ингэхчээд байгаа юм. Бага, дунд орлоготой, ялангуяа бага орлоготой иргэдийн хувьд бол нийт орлогын хэмжээ нь буцаагаад л яг зарлага болж гарна. Тэгэхдээ юу гэдэг юм ойролцоогоор 700 мянган төгрөг сардаа зарцуулдаг өрх байлаа гэж бодъё. Тэгэхэд бол энэ нийт 700 мянган

төгрөгийнх нь 90 хувь нь мах, сүү, гурил, боловсрол, эрүүл мэнд гээд дандаа нөгөө НӨАТ-гүй бараа худалдаж авчхаад байгаа юм. Тэгэхээр энэ хэсэг дээр бол ямар ч дэмжлэг болохгүй болчхоод байгаа юм. Тэгэхээр бид бага дунд орлоготой өрх дээр илүү төсөв талаас нь өөрөөр хэлбэл энэ бага, дунд орлоготой өрхийн маань гол орлого бас энэ хүмүүсийн хувьд бол цалин гол орлого биш байгаад байгаа юм. Тэтгэвэр, халамж гол орлого байгаад байдаг. Энэ хэсэг дээр нь илүү төсвийн чиглэлээр ажиллах нь зүйтэй байна гэдэг ийм агуулгаар бид харж ажиллаад байгаа юм.

Нөгөө талдаа бид нар өргөн барьчихсан байгаа төсвийн хүрээний мэдэгдэл дээр бол одоо орлого дотор энэ НӨАТ-ын хуулийг бид нар буцаана гэж тооцоод орлогыг нь ингээд тооцоод тавьчихсан байгаа. Тэгээд энэ хууль маань явахгүй болохоор тэр орлого маань бас буурах болчхоод саяын нөгөө бодлого маань Засгийн барьж байгаа энэ бодлого маань яг эсрэгээрээ яваад, илүү бид нар хэрэглээ талаас нь өрхүүдээ дэмжих болчхоод байгаа юм. Одоо бол бид нар бага, дундыгаа орлого талаас нь илүү дэмжье гэдэг ийм л агуулга яваад байгаа юм.

Н.Наранбаатар: Ганхуяг гишүүн тодруулъя.

Х.Ганхуяг: Үгүй ээ, харин тийм өргөн барьсан НӨАТ-ын нөгөө татварын багц хууль дээр чинь нөгөө НӨАТ-ын хуулийн юуг нь харлаа л даа. Тэгээд бид нар чинь бол нэлээн бас өмнө нь боловсруулчихсан байсан төсөл бол нэлээн урагш реформын шинж чанартай байсан байхгүй юу. Хөрөнгө оруулалт хийвэл НӨАТ-ын юу билээ. Нөгөө үндсэн хөрөнгөд хөрөнгө оруулалт хийвэл НӨАТ-ыг нь шууд буцааж яахаар хасагдуулалтыг нь тооцуулъя. Гар дээрээс зарж байгаа бүгдийг нь НӨАТ-тай дүн гэж тооцдог болъё. Тэр чинь бол нөгөө малчид ч байдаг юм уу, ногоочид ч ямар нэгэн санхүүгийн хүндрэл байхгүй байхгүй юу. Тэгээд тэр өөрчлөлтүүдээ та нар өөрсдөө энэ татварынхаа хуулиас хасаж хаяад тэгээд тэр юмнаасаа бүгдээс нь буцъя гээд явчаж байгаа байхгүй юу. Яах вэ, шууд 2027 онд хэрэгжүүлж чадахгүй ч гэсэн 2028 он, 2029 онд шат дараатайгаар бид нар хэрэгжүүлэх боломж байсан шүү дээ. Тэгээд наад зөвхөн мах, сүүн дээр яриад байгаа байхгүй юу. Тэгэхдээ энэ чинь хүнсний өрхийн хэрэглээ гэдэг маань эм байна, тариа байна, тэр шатахуун байна, түлш байна гээд зөндөө л юм байгаа шүү дээ. Зөвхөн мах, сүү, ногоо 3 дээр л авчаж байгаа байхгүй юу. Тэгснээ мах, сүү, ногоо 3 НӨАТ-ын юунаас хасчаж байгаа байхгүй юу.

Н.Наранбаатар: Асуулт уу. Мөнхсоёл гишүүн асуулт асууя.

Б.Мөнхсоёл: Өглөөний амар амгаланг айлтгая. Тэгэхээр нэмэгдсэн өртгийн албан татвартай холбоотой асуудлууд нэлээн хөндөгдөж байна. Тэгээд мэдээж төгс шийдэл гэж байхгүй. Тэгэхдээ жишээлбэл 1 том асуудлыг хөндмөөр байна. Занданшатар Ерөнхий сайдын үед энэ буцаан олголтыг 5 хувь болгосон. Одоо төсвийн орлого 1,6 их наядаар дутах нь гээд энэ буцаан олголтыг болиулах гээд байна гэдэг дээр хүмүүс эсэргүүцэж байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр би бас байр сууриа илэрхийлэхэд 5 хувь буцаан олголтоо хэвээр хадгалсан нь зүйтэй юм болов уу гэсэн ийм саналтай байгаа юм. Энэ дээр төсвийн орлого буурч байна гэдэг дээр бид нар тухайн үед 2016 онд НӨАТ-ын 2 хувийн буцаан олголтыг өгөх ийм шийдвэр гарах үед бол бас төсвийн орлого тасалдана гэдэг ийм асуудал үүсэж байсан. Гэтэл начир дээрээ үгүй. Тэгсэн ч гэсэн жишээлбэл 2016 онд НӨАТ-ын албан татвар 553 тэрбум төгрөг, 2018 онд 900 тэрбум төгрөг, 2021 онд 3,7 их наяд төгрөг 21 онд, одоо бүр 2026 оны батлагдсанаар 7,4 их наяд байна уу ямар өсөлттэй явж байгааг та нар хар даа. Төсвийн орлогын маш том эх үүсвэр болсон. Тэгэхээр анх үүсгэсэн

шалтгаан төдийгөөс өдий хүртэл явж байгаа хувьсал энэ тэрийг бас эргэж хараад, энэ 5 хувийн буцаан олголт чинь бага, дунд орлоготой иргэдэд маш их ийм дөхөмтэй зүйл болоод байна. Эдийн засгийн өсөлт гацсан, зогсонги байдалтай, инфляц өсөх 2 оронтой тоо руу орох ийм өндөр магадлалтай байгаа үед энэ бага орлоготой иргэдээ дэмжих хэрэгтэй байна.

Өөрөөр хэлэх юм бол дэмжинэ гэдэг нь худалдааг дэмжсэнээр эргээд эдийн засгаа идэвхжүүлэх, НӨАТ-ын татвар төлөлтийн бааз суурийг нэмэгдүүлэх замаар энэ орлогын түвшнээ хадгалах боломж харах ёстой юм болов уу гэсэн ийм байдалтай байна. Ер нь гишүүдийн болон иргэдийн шүүмжлээд байгаа зүйл нь амархнаар нь өсгөөд яваад байна. Нөгөө эдийн засгийн макро эдийн засгийнхаа цогц бодлогыг бусад талд нь бас давхар харж үзээч ээ. Далд эдийн засгаа ил болоход нь анхаараач ээ. Бага орлоготой иргэдийнхээ орлогыг хамгаалаач ээ. Өөр ажлын байр бий болгох, эдийн засаг, бизнесийн хөрөнгө оруулалтын таатай орчныг бий болгох замаар төсвийнхөө орлогыг татварын замаараа нэмэгдүүлээч гэсэн ийм саналуудыг тавиад байна шүү дээ. Энэ дээр тэгэхээр харж үзэх ёстой юм байна гэсэн ийм саналтай байгаад байгаа. Олон асуудлууд байна. Энийг л голчлоод хэлчихье.

Н.Наранбаатар: Үг хэлчхэв үү. Асуулт уу. Хэн хариулах вэ. Сангийн яам 8 номер.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр бид нар бол төсвийн бүх тооцоо, судалгаанууд, тоон мэдээллүүд юуг үзүүлээд байна гэхээр одоо дунд хугацаанд бид нар 2-3 жилийн хугацаанд маш өндөр инфляцын ийм дарамттай явах нь гэдэг нь бол харагдаад байгаа юм. Тэгэхээр бид нар бол яг инфляцын цохилтод хамгийн ихээр өртөх бага, дунд орлоготой хэсэг дээрээ ямар бодлого явуулах вэ гэдэг асуудал явчхаад байгаа юм. Тэгэхээр бид нар татварын бодлого явуулж 1 болж байна, 1 бол төсвийн бодлого явуулж болж байна. Тэгэхээр хэрэглээг нь энэ бага, дунд өрхүүд дээр харахаар хэрэглээг нь ч харахаар, орлогын эх үүсвэрийг нь ч харахаар хэрэглээний хувьд ихэвчлэн энэ НӨАТ-гүй бараа бүтээгдэхүүнүүд энэ хүмүүс дээр хэрэглээд байна. Зөвхөн мах, сүү, гурил биш, үүнээс гадна нийтийн тээвэр байж байна. Дээрээс нь боловсролын үйлчилгээндээ дийлэнх мөнгөө зарж байна. Эрүүл мэндийн үйлчилгээндээ, эм дээр дийлэнх мөнгөө зарж байна. Ингэхээр энэ хүмүүсийн хувьд буцаалт нь төдийлөн нэмэгдэхгүй.

Гэтэл сарын магадгүй 3 сая төгрөгийн хэрэглээтэй хүн чинь бол мах, сүү нь байсан ч гэсэн цаана нь НӨАТ-ын буцаалт нь хамгийн дийлэнх нь тэндээ л очих гээд байна гэдэг ийм тооцоо харагдаад байгаа юм. Тэгэхээр бага, дунд орлоготой иргэд дээр бид нар яг түрүүний таны хэлдгээр орлого дээр нь дэмжлэг үзүүлье гэдэг зүйл хэлээд байгаа юм. Орлого гэдэг маань энэ хүмүүсийн хувьд бол орлогын дийлэнх хэсгийг бас яг үндэсний статистикаас гаргасан тооцооллоос үзэхээр дийлэнх орлого нь бол халамж, дээрээс нь тэтгэвэр байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нар илүү энэ орлогоороо төсөвтөө орон зайгаа авч үлдээд, нөгөө талдаа халамж, тэтгэврээ нэмэх нь зүйтэй байна гэдэг ийм л хандлагаар хараад байгаа юм.

Түүнээс гадна Засгийн газрын хувьд бол төсвийн хууль, татварын хуулиудаа бас өргөн барьчихсан байгаа. Аж ахуйн нэгжүүд дээр бас ямар бодлого явах вэ гэдгийгээ бас бид нар тодорхойлчихоод байгаа юм. Энэ дээр аж ахуйн нэгжүүд дээр үүсээд байгаа проблем нь юу вэ гэхээр дотоодод юу гэдэг юм инфляцыг тэгж

өндрөөр нэмээгүй боловч урд хөршид бензиний үнийг 2 ч удаа нэмчихсэн. 1 нэмэхдээ бол бүр 600 төгрөг орчмоор манай ханшаар бол нэмчихсэн. Тэгэхээр бараа материал бол урд хөршөөс дандаа инфляцтайгаа өөрөө шууд орж ирчхээд байгаа юм. Тэгэхээр бид нар хүссэн, хүсээгүй урдаас инфляцыг нэмэгдсэн үнээр нь бид нар авчхаад байгаа юм. Тэгэхээр энэ маань өөрөө аж ахуйн нэгжүүд дээр зарлагаа дэндүү өсгөчхөөд байгаа юм. Нөгөө талдаа борлуулалтын орлогоо тэгж өсгөж чадахгүй болчихоод байгаа учраас илүү юу гэдэг юм ашгаас авдаг ААНОАТ дээр, мөн ажлын байрыг хадгалах зорилгоор ХХОАТ дээр энэ маань эргээд бас тэр өрхийн орлогоор нь ярих юм бол дунд болон дундаас дээш орлоготой яг энэ хэсэг дээр нөлөөлөх гээд байна гэдэг зүйлийг хэлсэн.

Тэгэхээр төсвийн болон татварын бодлогыг илүү хослуулж оруулж ирж байгаа гэж та бүхэн ойлгоорой. НӨАТ-ын хувьд бид бас 400 сая төгрөгийн босго оруулж ирж байгаа. Гэхдээ энэ дээр 10 сая төгрөгөөс дээшээ бол сайн дур шүү дээ. Тэгэхээр магадгүй 50 саяын борлуулалттай байсан ч гэсэн сайн дураар би НӨАТ төлөгч болно гэх юм бол болох боломж нь байгаа.

Н.Наранбаатар: Мөнхсоёл гишүүн тодруулъя.

Б.Мөнхсоёл: Төгс шийдэл гэж бол мэдээж байхгүй. Нэг талд шийдвэр гарахад нэг талд хожиж байхад, нөгөө талд хохирдог. Аль болохоор тэнцвэртэй явсан нь дээр гэдэг утгаараа ийм янз бүрийн хувилбарууд байдаг. Энэ дээр 1 л тоо асуучихъя. Тооцоолол дээр. 2 хувь буцааж байсан 5 хувь болгосон Занданшатар Ерөнхий сайдын үед одоо буцаад буцааж орж ирсэн 2-5 руу шилжихэд НӨАТ-ын татвар төлөгчдийн тоо хэр өссөн, буурсан. Орлого нь хэр өссөн, буурсан яг тэр завсрын үеийг харьцуулж үзсэн үү. Өмнөх болон дараа нь. Яг тэр тоо чухал шүү дээ дараа нь буцаах уу, үгүй юү гэдэг дээр. Яах вэ, нийт дүнгээрээ 1,6 их наядаар дутаж байгаа гэж байгаа. Төсвийн орлого НӨАТ-ын буцаан олголт 5 болсноос, 2-оос 5 руу шилжсэнээс. Гэхдээ энэ дээр бид нарын хэлэх гээд байгаа энэ дээрээ битгий анхаар, бааз сууриа өргөтгөхөд анхаар, худалдааг дэмж, амьжиргааг дэмж, ядуурал өндөр байна, бага орлоготой иргэдээ хамгаалъя гэдэг талаас нь шийдэл өгөх гээд яриад байхад цогцоор нь авч орж ирж байгаа халамж дээр, тэтгэвэр дээр, цалин дээр нэмье гэж байна шүү дээ. Гэхдээ энэ чинь эргээд өөрөө нөгөө инфляцтайгаа холбоотой шүү дээ. Тэгэхээр энэ албаар өдөж асууж байна. Энэ тоог хэлээд өгөөч.

Н.Наранбаатар: Хэн хариулах вэ. 9 номер.

Ч.Чимидсүрэн: Мөнхсоёл гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр 2 хувийн буцаалт бол 1 жилдээ 360-70 тэрбум байгаа юм. Тийм тэгэхээр 5 хувийн буцаалт хэрэгжиж эхлээгүй байна. 10 дугаар сарын 1-ээс эхэлнэ. Тэгэхээр бидний тооцоолж байгаагаар жилийнх нь 1,6 их наяд. Тэгэхээр яг 5 хувийнх нь буцаалт нь 1 дүгээр улиралдаа бол 375 байна лээ. Бусад нь 400 орчим болох юм. Тэгэхдээ тэр нь нөгөө тохиргоо нь өөр ганцхан 50 хувиар биш, эхний 500-д нь 10 хувь, 500 мянгаас 1 саяд нь бол 5 хувь, 1 саяас дээшхэд нь 2 хувь нь тийм болж байгаа юм.

Н.Наранбаатар: Мөнхсоёл гишүүн тодруулъя. Больсон байна. Булгантуяа гишүүн асуулт асууя.

Х.Булгантуяа: Би нэг ийм юм асуух гэсэн юм. Иргэдийн амьжиргааг эдийн засгийн хүндрэлтэй үед дэмжих гэж байгаа гээд НӨАТ-ын буцаан олголтынхоо хуулийг цуцлаад, ХХОАТ-ыг бууруулах үе шаттайгаар бууруулах тийм хууль та бүхэн маань өргөн барих гэж байгаа гэж би ойлгож байгаа. Бусад улс орнууд ингэж

байна. Япон бол НӨАТ-ын гэдэг шиг Consumption tax гэж байдаг. 10 хувь байдаг нийт ерөнхийдөө. Хүнсний бүтээгдэхүүн дээр бол 8 хувь байдаг. Японы шинэ Ерөнхий сайд сая дахин сонгогдохдоо хүнсний бүтээгдэхүүнийхийг 2 жилдээ 0 хувь болгож бууруулъя гэдэг ийм бодлого барьж байна.

ХХОАТ-ыг бууруулаад хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийнхээ орлогыг дэмжих бодлого барья гэвэл ийм нөхцөл байдал үүсчхээд байгаа юм. Сангийн яамныхан, Эдийн засаг, хөгжлийн яамныхан Монголын нийт өрхийн 30 орчим хувь нь цалин авдаггүй, тэтгэврээрээ амьдардаг, халамжаар амьдардаг ийм өрхүүд байна. Тэгэхээр та бүгдийн ХХОАТ-ыг бууруулж иргэдийн амьжиргааг дэмжинэ гэж байгаа бол энэ хүмүүст огт падлийгүй болчхоод байна. 500 орчим мянга Монголд тэтгэвэр авагчид байгаа гэж та бүхэн өөрснөө сайн мэдэж байгаа. Тэгэхээр эсрэгээрээ энэ хэсэгт уг нь хамгийн их дэмжлэг хэрэгтэй байгаа байхгүй юу. Эдийн засгийн хүнд цаг үед. Тэгэхээр тэр дэмжлэгийг яах юм бэ. Эсвэл та бүхэн тэтгэврийг тултал нь сайн нэмье гэж бодож байгаа юм уу. Эсвэл халамжийг нь нэлээн нэмнэ гэж бодож байгаа юм уу. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс авхуулаад хөгжлийн бэрхшээлтэй хүнийг харж, асарч байгаа, ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа зайлшгүй шаардлагатай айл өрхүүд Монголд байгаа шүү дээ. Тэгэхээр уг нь бол ялангуяа Японы энэ бодлого бол яаж байгаа вэ гэхээр хүнсний бүтээгдэхүүн бол хүний амьдралын наад захын хэрэгцээ. Энэ бол тансаг хэрэглээ бас биш байхгүй юу. Наад захын хэрэгцээ. Тэгэхээр энийг 0 хувь болгоё. Энэ дээр бас татварын нэлээн том орлогын юу үүсэж байгаа юм байна. Тэр дээрээ тооцоолол хийж байгаа юм байна. Тэгэхээр та бүхэн энэ өрхүүдийг яаж дэмжинэ гэж бодож байгаа юм бэ. 1 дүгээрт.

2 дугаарт аягүй том их зардал гаргаад энэ сая НӨАТ-ын буцаан олголтын хуулийг хийхэд манай Улсын Их Хурлын гишүүдээс бараг л 4, 5 орноор явж туршлага судалж судалж, баахан зардал гаргаж гаргаж, энэ хуулийг боловсруулаад, өргөн бариад батлуулснаа хагас жил болоод ингээд буцаачих юм. Хэрвээ ийм байсан юм бол ийм их зардал, ийм их ажиллагаа хийж байж үүнийгээ арай гэж батлуулаад, ард түмэнд хүлээлт үүсэх хэрэг байсан юм уу. Та бүхэн яг үүнийг зөв шүү дээ гээд яриад сууж байсан хүмүүс өөдөөс хараад одоо буруу шүү дээ, энэ чинь НӨАТ-ын буцаан олголт худалдан авалт ихтэй айл өрхүүдэд болохоороо сайнаар тусаад байгаа юм. Үгүй ээ, тэрийг та нар өөрсдөө мэдэж байсан шүү дээ тухайн үед. Тэгээд одоо яагаад гэв гэнэт ухаан ороод, шал өөрөөр яриад эхлэв. Надад энэ 2 асуултад хариулаад өгөөч.

Н.Наранбаатар: 8 номер хариулъя.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Япон бол Consumption tax, хэрэглээний такстай. Манайх бол нэмэгдсэн өртгийн албан татвартай. Энэ бол өөрөө үйлчилгээ болгон дээр бол яаж нэмэгдэж байна. Тэрүүгээр явдаг. Нөгөө талдаа Японы хүн ам энийг бас бид нар судалж үзэж байсан. Энэ хүмүүсийн хувьд бол орлогын түвшин нь харьцангуй дундаж хэсэг нь массыг эзэлдэг. Манайхыг бодох юм бол арай өөр. Тэр агуулгаараа бол эдийн засаг нь өөрөө ингээд унаж байгаа, тэгээд дээрээс нь инфляц бараг байхгүй болж байгаа энэ үе дээрээ бол хэрэглээгээ нэмэх байдлаар аж ахуйн нэгжээ дэмжих ийм бодлого явуулаад байгаа гэж ойлгоод байгаа. Өөрөөр хэлбэл эд нарын хувьд инфляц проблем биш болчхоод байгаа юм. Бидний хувьд инфляц проблем болчхоод байгаа. Тэр агуулгаараа бид нар ажлын байрыг хадгалах, тэгээд бага, дунд орлоготой иргэдийнхээ орлогыг хамгаалах чиглэлээр, төсвийн чиглэлээр бодлого явуулах нь бас зүйтэй болчхоод байна гэж бодоод байгаа юм. Тэгэхээр зарим хэсэг, сегмент дээр бол төсвийн чиглэлээр, зарим хэсэг дээрээ татварын чиглэлээр

бодлого явуулъя гэж байгаа юм. Тэтгэврийн асуудлыг одоо бол баталсан хуулиар бол өмнөх оны инфляцын түвшинтэй уялдуулж тэтгэврийг нэмэхээр бол хуультай байгаа. Энэ дагуу бид нар ирэх жилийн төсөв дээр орж ирэх болов уу гэж бодож байна. Одоо бол инфляц бол 2 оронтой тоонд хүрчихсэн. Тэгэхээр ирэх жил тэр орчимд нэмэгдэх болов уу гэсэн ийм юм харж байгаа.

Халамжийн асуудлын хувьд бол Засгийн газраас бол Гэр бүлийн тухай хууль, Халамжийн тухай хуулийг зэрэг боловсруулаад, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлээд, одоо Их Хуралд ингээд өргөн барьж байгаа. Энэ хууль маань яаж байна гэхээр хүн амын бодлогоо илүү тусад нь гаргаад, тэгээд яг зорилтот халамжаа бол Халамжийн хууль дээр авч үлдээд ингээд өргөн барьж байгаа.

Тэгэхээр бид энийг юу гэж харж байна гэхээр халамжийн яг зорилтот бүлэг дээр бол халамжаа илүү түлхүү нэмэх боломж гарах болов уу гэдэг ийм байдлаар бол харж байгаа. Нөгөө талдаа халамжийг бас мөн жил болгон тодорхой хэмжээгээр нэмэх ийм бодлогоо бас бид нар нэвтрүүлнэ гэж үзэж байгаа.

Мөн цалинтай холбоотой эсэх дээр бол бас одоо ингээд байгууллага болгоны хувьд, салбар болгоны хувьд бол өөрсдийнх нь салбарын хуулиар нийтдээ 30 гаруй хуулиар зохицуулж байгаа. Энэ хуулиудаа нэгтгээд, Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны хуулийг. Гэхдээ гол нь цалин нэмэхээс гадна үр дүнг нь яаж хэмжих вэ, гүйцэтгэлийг нь яаж хэмжих вэ гэдэг энэ асуудлаа энэ хууль дээр бол давхар оруулж ирнэ гэж бол хүлээлттэй байгаа. Энэ хуулийг намрын чуулган дээр өргөн бариад, ирэх оны 1 сарын 1-ээс өмнө батлагдсан тохиолдолд бол ирэх оны 1 сарын 1-ээс цалингаа ч тэр, тэтгэврээ ч тэр нэмээд явах ийм бодлого барьж байгаа. Тэгээд хамгийн гол нь энийгээ хуульчлах гээд байгаа нь бол дараа нь савлаж, огцом байдлаар цалин хөлс тэтгэврээ нэмэхээс ч илүүтэй .../минут дуусав/

Н.Наранбаатар: Булгантуяа гишүүн тодруулъя.

Х.Булгантуяа: Манайхан асуух тусам улам заримдаа буруу тайлбарлаад болохгүй юм. Шинэ хуулиар халамж бол яг олигтой бол нэмэгдэхгүй шүү дээ. Зүгээр хүн амын өсөлтийн чиглэлийн хүүхдийн мөнгө байдаг юм уу, эд нарыг бол халамжийн хуулиас илүүтэйгээр Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуульд оруулаад, энэ бол хүн амын өсөлтийн чиглэл рүү гэх мэтчилэн хийнэ гэж хууль нь бичигдсэн байна лээ. Би зүгээр ингэж л асуугаад байгаа юм л даа.

Одоо тэгээд нөгөө ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа, бас халамжаар амьдардаг Монголын нийт өрхийн 30 хувийг яах вэ. Тэр хэсэг бол хамгийн их үүнд өртөж магадгүй байгаа хэсэг байгаад байгаа. Дээрээс нь нэмээд уг нь ХХОАТ-ыг ч гэсэн зөвхөн хоосон жишээлбэл ямар ч юугүйгээр критергүйгээр зөвхөн орлогоор нь хэмжиж бууруулах биш, тухайн хүн хэчнээн хүнийг тэжээж байгаа вэ гэдгээр нь дэлхийн улс орнууд уг нь Dependency ratio шүү гэдгээр нь багасгадаг. Би 10 сая төгрөгийн цалинтай байж болно. Тэгэхдээ би ганц бие байх юм бол өндөр татвар төлөх нь окэй. Харин би жишээлбэл 10 саяас дээш төгрөгийн цалинтай, тэгэхдээ би 4, 5 хүүхэдтэй, дээрээс нь нэмээд эхнэр нь гэртээ ажилгүй, хүүхдээ хараад сууж байгаа ийм байх юм бол миний татварыг бүр бууруулдаг. Эсвэл би боловсролын зээлтэй. Би амьдралынхаа наад захын баталгааг хангах гэж нийгэмд үр бүтээлтэй иргэн болох гэж зээл авсан хүн байх юм бол татвар нь буурдаг ч байдаг юм уу ийм хөшүүргүүдийг уг нь хийж өгдөг. Тэгээд би уг нь тэгэх болов уу гэсэн хүлээлт байсан. Тэгэхээр яг энэ хэсэг рүү л хүрч чадахгүй л болчихоод байдаг та бүгдийн энэ бодлого.

Н.Наранбаатар: Хэн хариулах вэ. 5 номер.

С.Даваасүрэн: Булгантуяа гишүүний асуултад хариулъя. Ер нь сая орлого багатай иргэдийн хувьд, мөн халамж хүртэж байгаа иргэдийн хувьд энэ асуултын хувьд бол хамгийн чухал нь хөдөлмөрийн зах зээл байгаа. Тэгэхээр хөдөлмөрийн зах зээл дээрх ажлын байрыг бий болгох явдал нь л манай эдийн засагт бол хамгийн чухал тулгамдсан асуудал болоод байна. Яг үүнтэй холбоотойгоор бүтцийн өөрчлөлтийн асуудал бол хийж байна. Өөрөөр хэлбэл эдийн засгаа төрөлжүүлнэ гэж олон жил ярьж байсан. Энэ үйл явц дээр хөдөө аж ахуйн салбар дээр нэлээд хэмжээний гэрэл гэгээ бол гарч эхэлж байна. Өнгөрсөн онд 33,2 хувийн өсөлттэй байсан. Хөдөө аж ахуйн салбарын хувьд бол Монгол Улсын ажиллах хүчний үндсэндээ 25 хувийг шингээж байгаа ийм зах зээл. Гэтэл нөгөө эдийн засаг дээр нэлээн түлхүү байгаа уул уурхайн салбарын хувьд бол ажиллах хүчний ердөө 7 хувийг нь бол шингээж байна. Яг үүнээсээ цалингийн ялгаатай байдал ч гэсэн бий болж байгаа. Тэгэхээр аль болох ажлын байрыг нэмэгдүүлэх, нэмэгдүүлж байгаа энэ салбарыгаа дэмжих явдал бол хамгийн чухал байна. Орлогын хувьд бол бага орлоготой иргэдийн хувьд ч гэсэн аль болох ажлын байраар хангах, МСҮТ-ийн үйлчилгээнд хамруулах, зөвхөн их дээд сургуульд суралцах биш энэ чиглэлийн үйл ажиллагаа бол нэн чухал гэдэг нь харагдаж байна. Зайлшгүй нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах тэр хэсэг бүлэгтээ бол Нийгмийн халамжийн хуульд шинэчилсэн найруулгыг хийж байгаа. Энэ хүрээнд бол ирэх онд 2,8 их наяд, 2028, 2029 онд бол 2,9, 3,1 их наядыг энд бол тусгайлан төлөвлөсөн. Энэ нь ДНБ-ий үндсэндээ 2,5 хувь орчим байхаар. Ахмадын хувьд бол тэтгэврийг инфляцын түвшинтэй уялдуулж жил болгоны эцэст ингээд нэмэх энэ бодлогыг бас баримталж явж байгаа. Энэ нь төсвийн хүрээнд бол тусгагдсан байгаа.

Н.Наранбаатар: Хэдэн удаа тодруулчихлаа. Булгантуяа гишүүн тодруулъя.

Х.Булгантуяа: Эдийн засаг, хөгжлийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас гаргасан хөдөлмөрийн зах зээлийн судалгааг та бүхэн маань аваад хараарай. Яг одоо бол үнэнийг хэлэхэд 3,4 сая хүн амаас 1,3 сая нь хүүхдүүд, 500 мянга нь тэтгэвэр авагчид, 200 орчим мянган оюутнууд, тэгээд дээрээс нь нэмээд хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа иргэд, ингээд гадаадад байгаа иргэдээ хасахаар 1,2 сая орчим хүн НДШ төлөөд, татвар төлж байгаа. Монголд ажил хөдөлмөр хийж болохоор иргэдийн бараг ихэнх нь ер нь бол ингээд хамрагдчихаад байна гэдэг ийм судалгаа гарч байна лээ. Зүгээр хөдөлмөрийн зах зээл дээр та бүхэн эдийн засаг ийм хүнд байхад иргэдийн орлогыг хамгаалахын тулд хөдөлмөрийн зах зээл рүү гаргана гэж хэлж байгаа чинь эдийн засаг чинь ийм хүнд байхад яаж ажлын байр бий болох юм бэ.

Дээрээс нь нэмээд 2012 онд Монгол хүний дундаж цалин доллароор илэрхийлэхэд 420 доллар байсан байна. 2022 онд 460, 470 доллар болж л нэмэгдсэн байна. Тэгэхээр иргэд яагаад бас ингээд үнэнийг хэлэхэд албан секторт ажил хийж чадахгүй байна гэхээр цалин нь олигтой нэмэгдэхгүй байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр ийм шалтгаануудаас болж хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаад байгаа юм. Ахмадуудыг хөдөлмөр эрхлүүлэх гээд Ахмадын тухай хууль дээр бид нар 50 ажилтан тутамд 1 ахмадыг авч ажиллуулахаар хуульчилсан юм. Энэ хуулийн хэрэгжилт бас тааруухан байгаад байгаа юм яг үнэнийг хэлэхэд.

Тэгэхээр эдийн засаг сайн байхад бол ажлын байр шинээр бий болно. Залуучуудад нь ажил олдохгүй байхад манай ахмадуудад ажил олдоход бас хэцүү шүү дээ. Цалин өндөртэй. Тэгэхээр яг одоогийн бодлого бол хөдөлмөрийн зах зээл

рүү халамж авч байгаа иргэдийгээ гаргаж, орлогыг нь нэмэгдүүлэх гээд байгаа юм гэдэг бол эдийн засаг хүнд байгаа цаг үед бол худлаа шүү дээ та бүхэн өөрснөө тэрийгээ сайн мэдэж байгаа. Тэгэхээр энэ бол орлого багатай иргэдийн амьжиргааг дэмжих бодлого биш шүү. Та бүхэн маань өөр юм бодож оруулж ирээрэй. Үүнийг хийхгүйгээр хэдүүлээ .../минут дуусав/

Н.Наранбаатар: Үг хэлчихлээ. Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Би асуулт байхгүй. Зүгээр энэ ийм техникийн юмыг манай 2 Байнгын хорооны ажлын алба бас анхаараач л гэж байгаа юм. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай гээд бид санаачилж байна шүү дээ. Энэ Улсын Их Хурлаас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцсугай гээд. Тэгэхээр энэ хууль чинь өөрөө эргээд юу гэдэг юм бэ дээ, тодорхой Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 15.2.1-ийг өөрчлөн найруулаад тэр өмнөх заалт чинь үндсэндээ хүчингүй болчихсон гэсэн үг. Энэ хуулийг хүчингүй болгосноор тэр заалт сэргэж ирэхгүй шүү.

Тэгэхээр ийм нэг техникийн юм байна. Тэгээд сүүлдээ аль ч бүр нэмэгдсэн өртгийн хуулийн аль ч заалтгүй болоод ийм ойлгомжгүй юм болчих вий дээ. Энэ хэдийгээр батлагдсан хууль мөн боловч хүчин төгөлдөр болоогүй байгаа. Хүчин төгөлдөр болоогүй хуулийг хүчингүй болгосноор тэр өмнөх заалт бол сэргэж ирэхгүй шүү. Тэгээд бүр ингээд их ойлгомжгүй байдал руу ороод, энийгээ Засгийн газар ч гэсэн анхнаас нь өргөн барихдаа хууль зүйн зөв техниктэй орж ирэх ёстой байсан. Тэгээд энийг ингээд мэдэхгүйгээр сүүлдээ юм их замбараагүй болж ирж байна. Зүгээр ингээд дур дураараа ингээд л явчихдаг. Энэ бол хууль зүйн техникт ерөөсөө байж болохгүй ийм техник. Тэгэхээр тэр заалтыг бараг энэ хуулийг хүчингүй болгож байгаа бол өмнөх чинь ч байхгүй болно, энэ ч байхгүй болно. Тэгэх юм бол харин нэмэгдсэн өртгийн албан татварын өмнөхөөрөө явъя гэж байгаа бол тэр заалтыг сэргээж нэмж хууль зүйн техникийн хувьд ч хууль орж ирэх ёстой байхгүй юу. Би энийг протоколын хувьд үлдээчихье.

Тэгээд юманд саад болох гээд байгаа юм биш. Зөв хийгээч ээ. 1 юмыг хийхдээ хууль зүйн техникүүдийг бүгдийг нь эвдэж, муйхарлаад ингээд хүчээр битгий зүтгээд байгаач ээ гэж л хүсэж байна.

Н.Наранбаатар: Үг хэллээ. Ганбаатар гишүүн асуулт асууна.

Г.Ганбаатар: Энэ НӨАТ-ын хууль буцаалт 6 сарын өмнө ярьсан хуулиа ингээд эргээд хүчингүй болгох тухай, ахиад энэ хууль нь техникийн хувьд сая Сайнзориг гишүүн маань их тодорхой ярьж байна. Бид нар жоохон ухралт л болоод байна шүү дээ. Ний нуугүй хэлэхэд. 6 сарын өмнө ярьж байсан баталсан хууль нь бас хараахан хэрэгжээгүй байхад манай зам зуур нь бараг нөгөө аборт хийчхэж байгаа юм уу, яаж байгаа юм. Тэгэхээр Сангийн яамны нөхдүүдийг би гайхаад байгаа юм. Өнгөрсөн жил бид нар 11 сард хэлэлцэж байхад та нар яагаад тэгвэл тэр Занданшатар Ерөнхий сайд байсан байх, бид нар хэрэглээг нь дэмжихгүй, орлогоо дэмжинэ гэж хэлж болоогүй юм. Одоо болохоор та нар бүгдээрээ чухам л орлогоо дэмждэг, хэрэглээ дэмждэггүй баатрууд болоод 1 дүгээрт нь.

2 дугаарт нь энэ чинь 1 саяас дээш болохлоор угаасаа ингээд хязгаарлалт тавиад өгчихсөн тэр өндөр хэрэглээтэй хүмүүс нь хэвээрээ л байгаа шүү дээ. Яагаад

ингээд худлаа яриад байдаг юм. Эсвэл 6 сарын ой санамжтай юм уу та нар чинь. Тухайн үед орж өчнөөн хэлэлцүүлэг болж байхад та нар өөр л юм яриад байсан шүү дээ. Тэгээд одоо болохоор чухам хэрэглээгээ дэмжих үү, орлогоо дэмжих үү ийм сонголтын өмнө байгаа ч гэх шиг.

Дээрээс нь тэр орлогыг нь дэмжээд байгаа хэлбэр чинь энэ НӨАТ-ын хэрэглээгээ дэмжээд байгаа хэлбэр 2 чинь төсөв дээр ирж байгаа ачаалал нь хэд юм. Надад энэ тоог нь хэлээд өгчих.

2 дугаарт нь бага орлоготой иргэд ихэнх нь НӨАТ-гүй бараа аваад байгаа юм л гээд байх юм. Үгүй ээ, энэ чинь НӨАТ-гүй бараанаас гадна өөр юм авч байгаа шүү дээ бас. Та хэд инфляцад хамгийн их өртөх, бага орлоготой иргэдээ хамгаалах тухай сая яриад байна л даа. Санжаа, Сангийн яам эд нар. Тэгвэл одоо энэ инфляц чинь Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс дунд хугацаандаа инфляц бүр маш өндөр байх нь гээд. Тэгээд та нар энэ төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөө дүгнэлттэй уялдуулаад энэ бодлогоо бүр өмнө нь ярьж болоогүй юм уу.

Миний 2 дахь асуулт бол хөдөө орон нутагт явж байхад аялал жуулчлалынхан, хөдөө аж ахуйн салбарынхан, үйлчилгээний салбарынхан ерөөсөө ажиллах хүч байхгүй болчихсон. Мэдээж уул уурхайтай өрсөлдөж чадахгүй. Уул уурхайн цалинтай энэ салбар чинь өрсөлдөж чадахгүй шүү дээ. Манай энэ улс орон ерөөсөө Голланд өвчинд нэрвэгдчихээд, ажиллах хүч байхгүй, цалингаа өгч чадахгүй, тэгээд энэ цалин, орлогоо нэмэгдүүлэх боломжоор хомс эдгээр салбар дээр хөдөлмөрийн зах зээл дээр хүндрэл учраад байгаа үед нь та нар хамгаалах ямар бодлого явуулах юм бэ. Хэдийгээр яг одоо энэ хэлэлцэж байгаа асуудалтай хамаагүй ч гэсэн энэ цаашдаа энэ Голланд өвчнөөс үйлчилгээний салбар, хөдөө аж ахуйн салбар, бусад салбараа хамгаалах бодлого явуулахгүй бол энэ үйлчилгээний салбар бусад салбарууд чинь уналаа. 1960-аад оны үед Голландад гарч байсан нийтлэг ийм хүндрэлээс л болж энэ Голланд өвчин ингээд бий болсон. Үүнтэй холбоотой .../минут дуусав/

Н.Наранбаатар: 8 номер хариулъя.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж гишүүний асуултад хариулъя. Ноднин НӨАТ-ын хуулийг батлуулж байсан нөхцөл байдлаас энэ удаагийн одоогийн нөхцөл байдал бол 1 зүйлээрээ аягүй их том ялгаа гараад байгаа юм. Тэр нь юу вэ гэхээр дунд хугацаанд бол инфляц их өндөр байх нь гэдэг нь тодорхой болчхоод байгаа юм. Тэгэхээр бид нар инфляцын өндөр үед яг иргэдийн аль хэсэг хамгийн их цохилтод өртдөг вэ гээд үзэхээр бага, дунд орлоготой хэсэг болчхоод байгаа юм. Бага, дунд орлоготой хэсгийн маань үндсэн зарлага маань юу руу явчхаад байна гэхээр жишээ нь 700 мянган төгрөг хүртэл зарцуулалттай нийтдээ 83,5 мянган өрхийн маань нийт зарцуулж байгаа тэр зарлагынх нь 90 хувь нь огт НӨАТ-гүй бараан дээр явчхаад байгаа юм. Тэгэхээр энэ хүмүүсийн НӨАТ-ын буцаалт бол тэгж их нэмэгдэхээргүй байна гэдэг зүйл харагдаад байгаа юм.

Нөгөө талдаа бага дунд орлоготой иргэдийн маань өрхийн орлого нь юунаас бүрдээд байна гэдэг нь харагдаад байгаа юм. Тэр нь болохоороо Үндэсний статистикийн яг энэ мэдээнээс авч байгаад үзэхээр цалин гэхээсээ илүү халамж, тэтгэвэр байгаад байгаа юм яг энэ хэсэг дээр. Тэгэхээр бид нар татварын бодлогоосоо илүү халамж, тэтгэвэр буюу төсвийн бодлогоороо энэ иргэдийнхээ хэрэглээг илүү хамгаалах юм байна гэдэг нь бол харагдаад байгаа юм. Нөгөө талдаа бол дунд орлоготой хэсэг дээр дунд, дундаас дээшээ дээр бид нар ямар

бодлого барих вэ гэдэг энэ асуудал гарч ирээд байгаа юм. Энэ бол яг өнөөдөр ажилтай байгаа хүмүүсийн хувьд. Тэгэхээр ингээд үзэнгүүт бид нар бизнес талыг нь сегментэлж үзэж байгаа юм. Одоо бол зөвхөн уул уурхайн салбарын бизнесийн юм ашиг бол тодорхой хэмжээнд арай гайгүй байна. Бусад салбаруудын хувьд ашиг нь бол нэлээд буурсан буюу инфляцаа дагаад гаднаас урд хөршөөс орж ирж байгаа инфляцтай бараа бүтээгдэхүүнээс болоод зарлага нь нийт өсөөд, орлого нь тэгж их дагаж өсөөгүй болж таарчхаад байгаа юм.

Тэгэхээр энэ хэсэг дээр бол бид нар ААНОАТ-ын илүү бодлогын хувьд бол оруулж ирэх ёстой. Дээр нь ХХОАТ-ыг бол бид нар оруулж ирэх ёстой. Ингэж байж энэ хүмүүсээ энэ дундаас дээшээ орлоготой иргэдийнхээ ажлын байрыг хадгалж байж бид нар орлогыг нь хамгаалах юм байна гэдэг ийм юм ярьж байгаа. Одоо бол бид нар Засгийн газрын хувьд цогцоор нь ямар ч байсан нэлээд хэдэн татварын зүйлүүдийг бол бид нар оруулж ирсэн. Өмнө нь бол Засгийн газрын хувьд бүр том хуулиудаар нь оруулж ирэх гэж байсан боловч энэ удаадаа төсвийн хүрээгээ дагуулаад ирэх жил дээр яг дунд хугацааны инфляцад ийм бодлого байх нь зүйтэй гэж бодож л бодлогын хувьд бол оруулж ирчхээд байгаа юм. Одоо бид нар НӨАТ-ын хуулийг хэрвээ буцаахгүй байх юм бол 1,6-1,8-ын орлого алдана гэдэг тооцоо байгаа.

Нөгөө талдаа бид нар яг энэ тэтгэвэр нэмэгдүүлэх, халамж нэмэгдүүлэх, цалин хөлс нэмэгдүүлэх дээр үүнээс арай өндөр зарлага гарах асуудал байгаа. ХХОАТ дээр тооцоолол бол 1,7 их наядын орлого алдах юм байна гэсэн ийм тооцоо байгаа. Гэхдээ энэ нь бол илүү/минут дуусав/

Н.Наранбаатар: Нэмээд хариулчих.

М.Санжаадорж: 2028 оноос ХХОАТ-ыг нөлөөлөхөөр оруулж ирсэн. Шалтгаан нь бид нар 2023, 2024, 2025 онуудад эдийн засгийн өсөлттэй үе байсан. 2026 оноос эхлээд бид нэлээд уналттай үе рүүгээ орж байна. 2028, 2029 оноос бид нар эдийн засаг буцаад сэргэх энэ мөчлөгийн үе нь бас тэгж таарч байна гэж үзэж байгаа. Энэ агуулгаараа бас бид нар 3 жилийн татварын бодлого маань бол үүнтэйгээ хамаатай байдлаар оруулж ирчхээд байгаа юм. Одоо энэ хууль маань хэрвээ батлагдахгүй тохиолдолд орлого бол 1,6-1,8 их наядар алдана. Тэгсэн тохиолдолд ирэх жилийн хувьд яг энэ Засгийн газрын нөгөө дэвшүүлсэн цогц бодлогын маань 1 хэсэг л байхгүй болчих гээд байна гэсэн үг. Өөрөөр хэлбэл ААНОАТ-ын тухай хууль, ХХОАТ-ын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулиа бол бид бас өргөн барьчихсан явж байгаа. Энэ хэсэг маань батлагдаад явчихна. Нөгөө талдаа төсвийн бодлого хэсэг маань яг энэ бага, дунд дээрээ дэмжлэг үзүүлэх төсвийн бодлого хэсэг маань батлагдахгүй болчих гээд байгаа учраас бидний хувьд цогцоор нь яг энэ асуудлыг бас явуулбал их зүйтэй байна. Та бүхнийг дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

Н.Наранбаатар: Ганбаатар гишүүн тодруулъя.

Г.Ганбаатар: Сангийн яамныхан энэ асуулт анхааралтай сонс л доо. Дутуу хариулаад байх юм. Тэр сүүлийнх нь хэсэг хэдийгээр хэлэлцэж байгаа асуудалтай холбоогүй ч гэсэн энэ Голланд өвчинтэй холбоотой, өөрөөр хэлбэл тэр цалин орлогоо нэмэгдүүлэх боломжгүй хөдөлмөрийн зах зээл дээр яаж бодлого явуулах юм бэ гэдэг асуулт байсан.

2 дугаарт нь Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс оруулж ирж байгаа тэр зөвлөмж дотор чинь ер нь энэ төсвийнхөө зарлагыг хязгаарлах бодлогоо явуулахгүй бол өнөөдөр үндсэндээ ДНБ чинь 32 хувь болчихоод байна шүү дээ. Тэгэхээр зөвхөн НӨАТ-тайгаа ноцолдох биш, төсвийн зарлагаа энэ өсөлтөө хязгаарлах энэ чиглэлийнхээ бодлогыг тодорхой ярих юм биш үү. Ингээд нөгөө юмны үнэ гэхээр нь махны үнэ яриад байдаг шиг, НӨАТ л яриад байх юм. Бүр энэ системээ, зарлагынхаа бүтцийг арай аятайхан ярьж, Эдийн засгийн яам, Сангийн яам энэ дээрээ ажиллах болоогүй юм уу. Хэрвээ энэ НӨАТ-ын чинь хууль орохгүй бол та нар 1,6-1,8 их наядын орлого тасарна гэж байна. Тэрийгээ яаж олох юм. Удахгүй төсвийн тодотгол хийх байх. Тэгвэл энэ чинь энэ бүтцээ, зарлагынхаа бүтцийг томоохон дорвитой өөрчлөлт хийхгүй л бол явахгүй нь байна шүү дээ.

Н.Наранбаатар: Үг хэлчхэв үү. Гишүүд асуулт асууж дууслаа.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан санал гаргах гишүүн байна уу. Алга байна. Улсын Их Хурлын гишүүн Заяабал гишүүний микрофоныг өгье.

Б.Заяабал: Тэгэхээр энэ төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцсийн хэлэлцүүлэгт батлах үе шат руу шилжүүлэх талаар горимын саналыг гаргаж байна.

Энэ хуулийн санал маань өөрөө Дэгийн тухай хуулийн 42.5 дээр Байнгын хороо хэрвээ зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулан Их Хурлаар шийдвэрлэгдсэн бол Байнгын хороо эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ хууль тогтоомжийн хоорондын уялдааг хангах зорилгоор холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулан хамтад нь хэлэлцүүлж болно гээд Байнгын хороо гээд заачихсан бас манай Дэгийн хуультай юм байна лээ. Тэгээд энэ цаг үе дээр бас Дэгийн тухай хууль явж байгаа үед гишүүдийн сая гаргасан саналын дагуу Дэгийн тухай хуулийг илүү тодорхой болгох чиглэлээр бас та бүхэн санал гаргаж ажиллахыг бас хүсье. Ингээд миний горимын саналаар санал хурааж өгнө үү гэсэн ийм хүсэлт байна.

Н.Наранбаатар: Заяабал гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Байнгын хорооны гишүүд санал хураалтад бэлтгэе. Зарчмын зөрүүтэй санал байхгүй учраас шууд нэгтгээд эцсийн хэлэлцүүлэгт шилжүүлэе гэсэн. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе рүү шилжүүлэх талаар Улсын Их Хурлын гишүүн Заяабалын гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. 51,3 хувиар дэмжигдлээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдааны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн хэн танилцуулах вэ. Танилцуулах уу. Мөнхсоёл гишүүн танилцуулна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаан дууслаа. Байнгын хорооны гишүүд болон ажлын хэсэгт баярлалаа.

11.52 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ